ÑÝËÝÍ ÃÝ ÀÉÌ ÀÃ ÄÀÕÜ ÖÀÃÄÀÀÃÈÉÍ ÃÀÇÐÛÍ
2018 ОНЫ 1 ДҮГЭЭР УЛИРЛЫН ¯ÉË
ÀÆÈËËÀÃÀÀÍ Û ÒÀÉËÀÍ

2018 оны 03 дугаар Ñ¿õáààòàð
сарын 23-ны өдөр ñóì

Тус Цагдаагийн газар нь 2018 оны 1 дүгээр улиралд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлж, Монгол Улсын Их хурал, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам болон дээд шатны байгууллагаас гаргасан хөтөлбөр төлөвлөгөө, Цагдаагийн дотоодын цэргийн байгууллагаас 2018 онд дэвшүүлсэн зорилт, удирдлагаас өгсөн үүрэг, ажлын чиглэл болон холбогдох эрх зүйн баримт бичигт тусгагдсан ажил, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллалаа.Үүнд:

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын талаар:

Монгол улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Аймгийн Засаг дарга, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоол шийдвэр, Цагдаагийн байгууллаãûí ¿éë àæèëëàãàòàé õî ëáî î òî é ¿¿ðýã äàòëãàâàð, õº òº ëáº ð, Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн дэд, дэд дарга, бусад алба, газрын дарга нараас ирүүлсэн албан даалгавар, үүрэг, ажлын чиглэлийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган Цагдаагийн ерөнхий газраас 2018 оны 1 дүгээр улиралд биелэлт үр дүнг тооцох баримт бичгүүдийг хугацаанд нь хүргүүлж ажиллалаа.

Монгол улсын Засгийн газрын тогтоол, Хууль зүйн сайд, Öàãäàòãèéí åðº íõèé ãàçðûí äàðãûí òóøàòë, º ãñº í ¿¿ðýã çº âëº ëèéí õóðàëäàòí û ø èéäâýðèéã тухай бүр í èéò бие á¿ðýëäýõ¿¿í ä танилцуулж, дээд газраас ирүүлсэн мэдээлэл, үүрэг, ажлын чиглэлийг хэлтэс, тасаг хэсгүүдэд хүргүүлэн, õýðýãæ¿¿ëýõ ажлын төлөвлөгөөг гаргуулж, үүрэг чиглэл өгч, хэрэгжилтийг сар бүр дүгнэж ажиллаж байна.

Тус Цагдаагийн газарт 2018 оны 1 дүгээр улиралд аймгийн төвд 757, Мандал сум дахь сум дундын цагдаагийн хэлтэст 389, Сайхан сум дахь сум дундын цагдаагийн хэлтэст 525, нийт 1671 албан бичиг хүлээн авснаас хариутай 637 бичгийн биелэлтийг цаг хугацаанд нь тооцон хариуг хүргүүлж, цагдаагийн газраас нийт 1755 албан бичгийг хүргүүлж, явуулсан бичгийн бүртгэлд хөтөлж ажиллав.

Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хуралдаанаар 2018 онд хэлэлцэх нийт асуудлын нэгдсэн төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулж, төлөвлөгөөний дагуу зөвлөлийн ээлжит болон ээлжит бус хуралдааныг 12 удаа хуралдуулж, удирдлага, зохион байгуулалтын чиглэлээр 9, хүний нөөцийн талаар 48, сахилга хариуцлагын талаар 15, бусад 2, нийт 73 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн.

Зөвлөлийн хуралдааны шийдвэрийг үндэслэн хэлтэс, тасаг, хэсгийн дарга нарт шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр 28 мэдэгдэл хүргүүлж, үр дүнг тооцон ажиллаж байна.Мөн сахилгын арга хэмжээ авагдсан болон ажлын үр дүнгээр цалин бууруулсан алба хаагчдад болон хариуцсан дарга нарт хугацаатай үүрэг, даалгавар өгч үр дүнг тооцож хэвшсэн.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2017 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/246 дугаар тушаалаар баталсан “Байгууллагын даргын тушаал гаргах журам” /код 136/-ыг үндэслэн Цагдаагийн газар, хэлтсийн даргын үндсэн үйл ажиллагааны чиглэлээр аймгийн төвд А дугаартай 13, хүний нөөц, боловсон хүчний чиглэлээр Б дугаартай 30, Мандал сум дахь сум дундын цагдаагийн хэлтэст 21, Сайхан сум дахь сум дундын цагдаагийн хэлтэст А дугаартай 14, Б дугаартай 8, нийт 86 тушаалыг

батлан гаргаж, бие бүрэлдэхүүнд танилцуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүний нөөцийн талаар: Тус Цагдаагийн газар нь батлагдсан орон тоогоор 288 орон тоотой ажиллахаас 2018 оны 1 дүгээр улирлын байдлаар газрын хэмжээнд 129 офицер, 116 ахлагч, 8 энгийн, нийт 253 алба хаагч ажиллаж, 2 офицер, 3 ахлагч хүүхэд асрах чөлөөтэй, нийт 5 сул орон тоотой, 5 офицер, 27 ахлагч, нийт 32 дутуу орон тоотой, хүний нөөцийн нөхөн хангалт 88,8 хувьтай байна.

Цагдаагийн ерөнхий газрын хяналт шалгалт, үнэлгээ, дотоод аудитын хэлтсээс ирүүлсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд тус цагдаагийн газрын хэсгийн байцаагчийн 1 орон тоог Захиргааны удирдлагын тасгийн төлөвлөлт, зохион байгуулалт хариуцсан ахлах мэргэжилтний, мөн эргүүлийн цагдаагийн 1 орон тоог Эрүүгийн цагдаагийн тасгийн шуурхай удирдлагын албаны телехяналтын камерын цагдаагийн орон тоонд тус тус шилжүүлэх асуудлыг шийдвэрлүүлэхээр холбогдох саналыг ЦЕГ-ын Хүний нөөц, сургалтын хэлтэст хүргүүлж, Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны 03 дугаар сарын 09-ний өдрийн Б/147 дугаар тушаалаар Захиргааны удирдлагын тасгийн төлөвлөлт, зохион байгуулалт хариуцсан мэргэжилтэн, Эрүүгийн цагдаагийн тасагт телекамерын жижүүрийн цагдаагийн орон тоог баталсан

Орон тоог үндэслэн Цагдаагийн газрын даргын тушаалаар телекамерын жижүүрийн цагдаагийн албан тушаалд алба хаагчийг томилж, төлөвлөлт, зохион байгуулалт хариуцсан мэргэжилтний албан тушаалд алба хаагчийг томилуулах саналыг ЦЕГ-ын Захиргааны удирдлагын газарт хүргүүлээд байна.

2018 оны 1 дүгээр улиралд цагдаагийн байгууллагад шинээр ажилд орох, суралцах хүсэлтээ гаргасан 9 иргэнийг судалж, ажлын байранд тавигдах шаардлага хангаж байгаа 7 иргэдийг нөөцийн бүртгэлд бүртгэсэн.

Тус цагдаагийн газарт шинээр 2 алба хаагч томилогдож, 11 алба хаагчийг хүсэлтийн дагуу ажлын байрыг өөрчлөн шилжүүлж, 7 алба хаагчийг дэвшүүлж, 5 алба хаагч өөрийн хүсэлтээр албанаас чөлөөлөгдөж, цэргийн байнгын тэтгэвэрт 3 алба хаагч гарч, 3 алба хаагч хүүхэд асрах чөлөө авч, албанаас халагдсан алба хаагч байхгүй байна.

2018 онд албан тушаал дэвшүүлэх шаардлагыг хангасан 20 алба хаагчийг нөөцөд бүртгэж, судалгааг гарган саналаа ЦЕГ-ын ХНСХ-т 2018 оны 01-дүгээр сард албан бичгээр хүргүүлсэн.

Тухайн улиралд алба хаагчдаас цагдаагийн дэд хурандаа-1, хошууч-1, ахлах дэслэгч-1, дэслэгч-2, дэд ахлагч-2, нийт 7 алба хаагч цол олгогдож, 1 алба хаагчийн цолыг бууруулж, сахилгын шийтгэл оногдуулсан.

Алба хаагчдаас Цагдаагийн ерөнхий газрын даргын баярын бичгээр 1, Эрүүгийн цагдаагийн албаны баярын бичгээр 1, Сэлэнгэ аймгийн хууль хяналтын салбарын аварга ажилтнаар 1 шалгарч тус тус шагнуулсан.

Байгууллагын үйл ажиллагаа түүнийг сайжруулах чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ: 2018 оны 1 дүгээр улиралд гудамж, талбай, обьектод ашиглагдаж байгаа хяналтын телекамерын болон урсгал засвар, зардлын тооцоо, судалгааг гаргаж, холбогдох байгууллагуудад хүргүүлснээр аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас Цагдаагийн газрын шаардлагатай тоног төхөөрөмж авахад зориулж 19 сая төгрөг шийдвэрлэж, байгууллагын гадна болон доторх телехяналтын камеруудыг шинээр сольж байршуулав.

Мөн тус аймгийн Алтанбулаг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаас Замын цагдаагийн тасагт 6.800.000 мянган төгрөгийн 4 ширхэг бэлэн бус торгуулийн багажны хөрөнгийг шийдвэрлүүлэн “uleFone” маркийн бэлэн бус торгуулийн багажийг хүлээн авч, үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд хийсэн ажил, арга хэмжээ: Шинээр батлагдан гарч буй хууль, тогтоомжууд, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны

журмуудаар алба хаагчдад сургалт зохион байгуулж, шинээр ирж буй мэдээ, мэдээллийг тухай бүр алба хаагчдад танилцуулан мэдээлэл өгч ажиллалаа.

Аймгийн Прокурорын газар, Мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран "Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд анхаарах асуудал" сэдэвт сургалт зөвлөгөөнийг зохион байгууллаа.Уг арга хэмжээнд Мэргэжлийн хяналтын газрын сумдад ажиллаж байгаа албан тушаалтнууд хамрагдан оролцов.

Тайлангийн хугацаанд аймгийн прокурор, мөрдөгч нарын хамтарсан зөвлөгөөнийг 1 удаа зохион байгуулан мөрдөн байцаалтын ажиллагаа, прокурорын хяналтын талаар хэлэлцсэн.

2018 онд зохион байгуулах хамтарсан сургалтын төлөвлөгөөг боловсруулан Аймгийн Прокурор, Цагдаагийн газрын дарга нараар батлуулан биелэлтийг тооцон ажиллаж байна.

Төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу шүүх, прокуророос буцаж буй хэргүүдэд анхаарах асуудал, шинээр батлагдсан Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Эрүүгийн хууль болон Улсын Ерөнхий Прокурорын заавар, удааширсан болон хугацаа сунган шалгагдаж буй хэргийн шийдвэрлэлтийн талаар сургалтуудыг хамтран зохион байгууллаа.

Мөн 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Хувь хүний хөгжлийн институттэй хамтран /багш М.Алтанцэцэг/ нийт алба хаагчдад "Миний үнэ цэнэ ба үнэт зүйлс", "Ухаалаг харилцаа-амжилтын эхлэл", удирдах албан тушаалтнуудад "Энгийнээр удирдахуй" сэдэвт сургалтуудыг зохион байгуулсан.

Төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажилласан талаар: "Хуулиа мөрдье-21" нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн Мэргэжлийн хяналтын газар болон Гэр бүл, хүүхэд залуучуудын газар, Боловсрол, соёл урлагийн газартай хамтран ерөнхий боловсролын сургуулиудын ахлах ангийн сурагчид болон багш нарт Зөрчлийн тухай хууль, аймгийн Архидалттай тэмцэх хөтөлбөр, Архины хор уршгийн талаар сургалт зохион байгуулж, гарын авлага, материал бэлтгэн тараалаа.

Мандал сумын Засаг даргын Тамгын газар болон дээрх байгууллагуудтай хамтран "Архины хор уршиг" сэдэвт "Дэвжээ" тэмцээнийг зохион байгуулсан.

Мэргэжлийн хяналтын газартай хамтран согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд 2018 оны 01 дүгээр сарын 25-30-ны өдрүүдэд хяналт шалгалтыг зохион байгуулж, зөрчил дутагдал илэрсэн аж ахуйн нэгжүүдэд зөвлөгөө өгч, зөрчлийг арилгах талаар мэдэгдэл, зөвлөмж хүргүүллээ.

"Зөрчил шалган шийдвэрлэх тухай болон Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд учирч буй хүндрэл" сэдэвт зөвлөгөөнийг аймгийн Прокурорын газар болон Шүүхтэй хамтран зохион байгуулж, зөрчил шалган шийдвэрлэх болон хэрэг мөрдөн шалгах эрх бүхий алба хаагч нар оролцов.

Монгол Улсын "Үндсэн хуулийг сурталчилах өдөр"-ийг тохиолдуулан Сүхбаатар сумын Засаг даргын тамгын газартай хамтран "Үндсэн хуулийн үзэл баримтлал, түүхэн хөгжил, нэмэлт өөрчлөлт оруулах нийгэм эдийн засгийн үндэслэл", аймгийн "Даатгуулагчдын холбоо", "Монре даатгал" компанитай хамтран "Гэнэтийн ослын болон бусад даатгалд хамрагдах ач холбогдол" зэрэг сэдэвт сургалтыг тус тус зохион байгууллаа.

Дээрх арга хэмжээг зохион байгуулж, арга хэмжээний талаар Цагдаагийн газрын цахим хуудас болон "Таны Сэлэнгэ", "Миний Монгол энтертаймент" телевизүүд, иргэдийн хамгийн их хандалттай "Сүхбаатар сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурал", "Сүхбаатар сумын ЗДТГ" зэрэг цахим хаягаар нийтэд сурталчлав.

Цагдаагийн газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, алба хаагчдаас ирүүлсэн болон алба хаагчтай холбоотой гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн талаар: 2018 оны 1 дүгээр улирлын байдлаар тус цагдаагийн газарт иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, алба хаагчдаас 7 санал, 2 гомдол, 194

өргөдөл, нийт 203 ирүүлснийг хүлээн авч 202 өргөдлийг шийдвэрлэн хариуг өгч, 1 өргөдлийн үлдэгдэлтэй байна.

Иргэд, байгууллагаас тухайн улиралд цагдаагийн 12 алба хаагчтай холбоотой 11 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулбал 6-аар буюу 54,5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Гомдол мэдээлэлд холбогдон шалгагдсан алба хаагчдын 5 буюу 45,4 хувь нь офицер, 7 буюу 54,6 хувь нь ахлагч алба хаагч байна.

Иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээлэл бүрт албаны шалгалт явуулж, дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, буруутай нь тогтоогдсон 1 алба хаагчийг албанаас халах саналтай, 1 алба хаагчийн цагдаагийн цолыг бууруулж, 1 алба хаагчийн гомдлыг Авлигатай тэмцэх газарт харъяаллаар шилжүүлж, 2 алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл 20 хүртэл хувиар бууруулж, 6 алба хаагчид сахилгын арга хэмжээ тооцох үндэслэлгүй байх тул алба хаагчид зөвлөлийн хуралдаанаас анхааруулан үүрэг чиглэл өгч, гомдол гаргагч нарт хариуг өгч шийдвэрлэв.

Нэвтрүүлсэн шинэлэг ажил, арга хэмжээ:Байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, алба хаагчид хандсан ажлыг зохион байгуулахад анхаарах зорилгоор 1 дүгээр сард алба хаагчдаас “*Хэрвээ би Цагдаагийн газрын дарга байсан бол*” сэдвээр эссэ бичүүлэн авч, Хилийн цэргийн 0101 дүгээр ангийн сэтгэл зүйчдийн багаар дүгнэлт гаргуулж, түүнийг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой ажлуудыг төлөвлөн ажиллаж байна.

Мөн Цагдаагийн газрын даргын зөвлөлийн ээлжит бус 05 дугаар хуралдаанаар “Төслийн хайрцаг” түүнийг хэрэгжүүлэх журмыг хэлэлцүүлэн шинэ санал, санаачлага гаргасан алба хаагчдыг шалгаруулан урамшуулж байхаар шийдвэрлэж, Цагдаагийн газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн А/08 дугаар "Төслийн хайрцгийг ажиллуулах тухай" тушаал батлагдснаар алба хаагчдад танилцуулж, хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Алба хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор албаны шалгалт явуулсан материалуудад алба хаагчдаар дүн шинжилгээ хийлгэж, зөрчил дутагдал гарах болсон шалтгаан, цаашид энэ төрлийн зөрчил дутагдлаас хэрхэн урьдчилан сэргийлэх, анхаарах асуудлыг талаар дүгнэлт гаргуулан нийт алба хаагч нарт танилцуулж, сахилгын зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж байна.

Цагдаагийн газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/06 дугаар тушаалаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд тасаг, албадын оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Хэвлэл мэдээлэл, урьдчилан сэргийлэх ажлын хэсэг”-ийг тасаг бүрээс нэг алба хаагчийг оролцуулан Захиргааны удирдлагын тасгийн даргын удирдлаган дор 7 хүний бүрэлдэхүүнтэй байгуулаад байна.

Мөн алба хаагчдын гэр бүлийн хүмүүсээс ОХУ-ын Буриад улсын Хиагт хот руу аяллаар явуулах, Сургалтыг шинэлэг байдлаар жүжигчилсэн тоглолт хэлбэрээр явуулах, зэрэг ажлуудыг зохион байгуулсан.

Бусад ажлын талаар: Цагдаагийн газрын 2017 оны үйл ажиллагааны тайланг аймгийн иргэний зөвлөл болон нийт сумдад 01 дүгээр улиралд багтаан тайлагнах хуваарь гаргаж, байгууллага, аж ахуйн нэгж, сумдад тайлангаа тавьж эхлээд байна.

Цагдаагийн газрын 2017 оны үйл ажиллагааны тайланг орон нутгийн “Миний Монгол энтертаймент” телевизтэй хамтран цахим хэлбэрээр бэлтгэж, тус телевизээр нэвтрүүлэн иргэдэд хүргэлээ.

Сүхбаатар сумын 1 дүгээр багийн иргэн Р.Төмөрбаатараас Цагдаагийн ерөнхий газрын даргад хандсан өргөдлийн дагуу тус Цагдаагийн газраас түүний эхнэр Л.Оюунчимэгтэй уулзаж, 100.000 төгрөгийн шатахууны талон, Захиргааны удирдлагын тасгийн алба хаагчдаас 50.000 төгрөгийн хандивыг тус тус хүлээлгэн

өгсөн бөгөөд “Өргөн Сэлэнгийн давалгаа” ном/1ш/-ыг байгууллагын номын санд ашиглахаар худалдан авч, мөн тасгийн алба хаагчид Сүхбаатар сумын 1 дүгээр багт байрлах нурсан хашааг засварласан.

Иргэн Р.Төмөрбаатар нь тус Цагдаагийн газарт 1983-1985 онд ажиллаж байгаад 2016 онд Сүхбаатар сумын 2 дугаар багаас өндөр насны тэтгэвэрт гарсан бөгөөд Цагдаагийн газрын алба хаагчдаас 2 удаа хашааг нь засварлаж өгч байсан болно.

Мөн Сүхбаатар сумын 8-р багт оршин суух иргэн Х.Отгонжаргалаас ирүүлсэн төрсөн охин У.Уужимзаяагийн ХБНГУ-д чөлөөт бөхийн тэмцээнд оролцох зардалд хандив хүссэн өргөдлийн дагуу газрын удирдлагууд 200.000 төгрөгийг сэтгэлийн дэм болгон хандивласан.

Хоёр:Гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр

Тус цагдаагийн газрын хэмжээнд 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас гэмт хэргийн шинжтэй 187, зөрчлийн шинжтэй 582 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаж шийдвэрлэжээ.

Гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээллийн 132-д нь хэрэг бүртгэлтийн хэрэг нээж, 44-д нь хэрэг нээхээс татгалзсан саналыг прокурорт хүргүүлж, нийт бүртгэсэн гомдол мэдээллийн 176 буюу 94.1 хувийг хуулийн хугацаанд нь шалгаж шийдвэрлэн, ажиллагаанд 11 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна.

Зөрчлийн шинжтэй гомдол, мэдээллийн 125-д нь зөрчлийн хэрэг нээж, 185-г хялбаршуулсан журмаар шалгаж шийдвэрлэж, 238-д зөрчлийн хэрэг нээхээс татгалзаж, 2 гомдлыг харъяаллын дагуу шилжүүлж, нийт гомдол мэдээллийн 550 буюу 94.5 хувийг хуулийн хугацаанд шалган шийдвэрлэж, ажиллагаанд 32 гомдол мэдээллийн үлдэгдэлтэй байна.

Нийт хүлээн авч бүртгэгдсэн 769 гомдол мэдээллийн 726 буюу 94.4 хувийг хуулийн анхны хугацаанд шалгаж шийдвэрлэжээ.

Аймгийн хэмжээнд 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар 86 холбогдогчтой 96.9 сая төгрөгийн хохиролтой, 121 гэмт хэрэг бүртгэгдсэн нь урьд оны мөн үеэс 16 хэргээр буюу 11.7 хувиар буурсан байна.

Хэрэг бүртгэлтийн 76 хэрэг бүртгэснээс 31-г эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татаж, гэмт хэргийн илрүүлэлт 40,8 хувьтай байгаа нь өмнөх оны мөн үеэс 43.6 хувиар буурчээ.

Үйлдэгдсэн байдлаар: - Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 43 бүртгэгдэж 7-гоор буюу 14.0%, Бүлэглэн үйлдсэн гэмт хэрэг 6 бүртгэгдэж 7-гоор буюу 53.8%, Хүүхэд оролцсон гэмт хэрэг 2 бүртгэгдэж 16-гаар буюу 88.9%, Эмэгтэй хүн оролцсон гэмт хэрэг 14 бүртгэгдэж 4-өөр буюу 22.2%, урьд ял шийтгэгдсэн хүмүүсээс дахин гэмт хэрэгт 21 хүн холбогдсон нь 9 хүнээр буюу 30.0%-иар буурч,

Галт зэвсгээр үйлдэгдсэн, Гадаадын иргэн оролцсон гэмт хэрэг тус бүр 1 бүртгэгдэж 1 дахин, Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 12 гэмт хэрэг бүртгэгдэж 4-өөр буюу 33.3 хувиар өсч, мансуурсан үедээ үйлдсэн гэмт хэрэг бүртгэгдээгүй байна.

Үйлдэгдсэн газраар: Гэр, орон сууцанд үйлдэгдсэн гэмт хэрэг 49 бүртгэгдэж 2-аар буюу 4.2%-иар өсч, Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг 11 бүртгэгдэж 3-аар буюу 21.4%, Олон нийтийн газарт үйлдэгдсэн гэмт хэрэг 9 бүртгэгдэж 9-өөр буюу 52.6%, Авто замд үйлдэгдсэн гэмт хэрэг 5 бүртгэгдэж 9-өөр буюу 64.3%-иар тус тус буурчээ.

Хэргийн төрлөөр: Хүний эрүүл мэндэд хохирол учруулах гэмт хэрэг 47 бүртгэгдэж 4-өөр буюу 9.3%-иар, Гэр бүлийн хүчирхийлэл үйлдэх гэмт хэрэг 12 бүртгэгдэж 3-аар буюу 33.3%, Гээгдэл эд зүйл, алдуул мал завших 4 бүртгэгдэж 4 дахин, Хууль бусаар мод бэлтгэх гэмт хэрэг 6 бүртгэгдэж 4 дахин, Хууль бусаар ашигт малтмал олборлох гэмт хэрэг тус бүр 3 бүртгэгдэж 3 дахин, Үндэсний аюулгүй

байдлын эсрэг, Нийтийн албаны ашиг сонирхлын эсрэг гэмт хэрэг тус бүр 2 бүртгэгдэж 2 дахин, Залилах гэмт хэрэг 8 бүртгэгдэж 2 дахин, Хүний амь нас болгоомжгүй хохироох гэмт хэрэг, Хөрөнгө завших, Хууль бусаар ан агнах гэмт хэрэг тус бүр 1 бүртгэгдэж 1 дахинаар өсч,

- Бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг 2 бүртгэгдэж 2-оор буюу 50.0%, Хулгайлах гэмт хэрэг 17 бүртгэгдэж 11-ээр буюу 39.3%, Дээрэмдэх гэмт хэрэг 1 бүртгэгдэж 2-оор буюу 66.7%, Мал хулгайлах гэмт хэрэг 7 бүртгэгдэж 3-аар буюу 30.0%, Хэрэг шалган шийдвэрлэх ажиллагааны эсрэг гэмт хэрэг 1 бүртгэгдэж 2-ээр буюу 66.7%, Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 10 бүртгэгдэж 3-аар буюу 23.1%-иар, Хүнийг алах гэмт хэрэг бүртгэгдээгүй ба 2 дахин, Олон нийтийн амгалан тайван байдал алдагдуулах гэмт хэрэг 4 бүртгэгдэж 4 дахин тус тус буурчээ.

Мөн өдрийн байдлаар нийт 4530 зөрчил илрүүлсэн нь 36 зөрчлөөр буюу урьд оны мөн үеэс 0.8 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Зөрчлийн улмаас 4435 иргэнийг 201.485.250 төгрөгөөр торгож, 119 жолоочийг торгож-тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг хасч, 95 хүнийг шүүгчийн шийтгэврээр /үүнээс: 56 буюу 56.3% нь гэр бүлийн хүчирхийллийн улмаас, 30 буюу 33.8% нь согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон/ баривчлуулан шийдвэрлэжээ.

2.1. Эрүүгийн цагдаагийн тасгийн үйл ажиллагааны чиглэлээр:

Тус тасаг нь 2018 оны 1 дүгээр улиралд нууц далд аргаар үйлдэгдсэн 44 холбогдогчтой 63.320.001 төгрөгийн хохиролтой, 35 хэргийг яллагдагчаар татаж Мөрдөн байцаах тасагт шилжүүлж, эрэн сурвалжлах “ASAP” санд бүртгэгдэн эрэн сурвалжлагдаж байсан 5 оргодол, гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээдийн хаягийг тогтоон дайчлан баривчиллаа.

Иргэд, аж ахуй нэгжээс 78 гомдол мэдээлэл хүлээн авч шалгаснаас хэрэг бүртгэлтийн хэрэг 30, үүнээс яллагдагчаар татсан 35, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 7, гомдол хүлээн авахаас татгалзсан 12, зөрчлийн хэрэг нээсэн 6, хялбаршуулсан журмаар шалгаж шийдвэрлэсэн 4, харъяаллаар шилжүүлсэн 15, ажиллагаанд 4 гомдол мэдээллийг шалгаж байна.

Аймгийн хэмжээнд үйлдэгдэх үедээ эзэн холбогдогч нь тогтоогдоогүй мал хулгайлах гэмт хэргийг илрүүлэх чиглэлээр хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулан ажилласны үр дүнд 2 гэмт хэргийг илрүүлэн ажиллаа.

Сумдын хýñãèéí төлөөлөгч í àðын цугларалтыг сàðын á¿ðèéí 20-ны өдөр àéì ãèéí òºâä зохион байгуулж, òóõàéí ñàðын ажлын үр дүнг тооцож, Цагдаагийн ерөнхий газар, Эрүүгийн цагдаагийн албанаас ирүүлсэн албан даалгавар, үүрэг, ажлын чиглэл, ýð¿¿, хэв журмын нөхцөл байдлын талаар тус тус танилцуулж, ñóðãàëò, дадлагыг çî õèî í ÿâóóëæõýâø ñýí .

Y¿íèé ¿ð ä¿íä алба хаагчид харилцан туршлагаа солилцож, Гэмт хэрэгтэй тэмцэх газрын даргын 2015 оны 02 дугаар сарын 27-ны өдрийн мн 5/20 дугаар тушаалаар батлагдсаны дагуу гүйцэтгэх ажилтнуудын хөтлөх бүртгэл, ñóäàëãààг шинэчилж, аймгийн хэмжээний сэжиг бүхий объект, субъектын ñóäàëãààí û цахим ñàí г баяжуулан ажиллаж байна.

Шинээр томилогдсон эрүүгийн мөрдөгч нарыг äàäëàãà òóðøëàãàòàé àõëàõ мөрдөгч, эрүүгийн мөрдөгч í àðò õàðèóöóóëàí ºã÷, àæèëä í ü õóðäàí äàäëàãàæóóëàõ чиглэлээр үүрэг чиглэл өгч, үр дүнг улирлаар тооцон ажиллаж áàéí à.

Ò¿¿í ÷ëýí àéì ãèéí òºâèéí ýð¿¿ãèéí мөрдөгч í àðò Ñ¿õáàòàð ñóì û í áàãийг õàðèóöóóëàõàòàñ ãàäí à øèí ý òºðëèéí ãýì ò õýðã¿¿ä áî ëî í õ¿í ä ãýì ò õýðãèéí òºðºë, ÷èãëýëýýð õàðèóöóóëàí àæëëóóëæáàéí à.

Эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр “Сан тулгалт”, “Бүртгэл судалгаа” нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний салбар төлөвлөгөөг боловсруулан ажлын

чиглэлийн биелэлтийг ханган, хүрээлэн байгаа орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх чиглэлээр аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газартай хамтарсан хяналт шалгалтыг 2 удаа зохион байгуулж, үр дүнг тооцон ажилласан.

Эрэн сурвалжилах, ASAP сангийн чиглэлээр хийсэн ажлын талаар:Тайлангийн хугацаанд эрэн сурвалжлах “ASAP” санд нийт 68 хүн, мал, амьтан, эд зүйлийн талаарх мэдээллийг бүртгэж эрэн сурвалжлах ажил зохион байгуулснаас 36 олж тогтоон, эрэн сурвалжлалтыг зогсоож, одоо 22 үлдэгдэлтэй, гүйцэтгэл 52,9 %-тай байна.

Иргэд, байгууллагаас эрэн сурвалжлалт зарлуулахаар ирүүлсэн оршин суугаа газраасаа алга болсон 18 хүнд эрэн сурвалжлалт зарлаж, холбогдох ажиллагааг хийж гүйцэтгэн 16 хүний байгаа газрыг олж тогтоон 2 хүний үлдэгдэлтэй, шүүхээс даалгасан нийт 14 хүнийг эрэн сурвалжилснаас 2 хүнийг олж тогтоон 14 хүний үлдэгдэлтэй байна.

Гэмт хэрэгт сэрдэгдсэн этгээд 16-г эрэн сурвалжилснаас 10 хүнийг олж тогтоон 6 хүний үлдэгдэлтэй, оргодол 6-г эрэн сурвалжилснаас 5 оргодлыг олж тогтоон 1 үлдэгдэлтэй, эд зүйл 13-г эрэн сурвалжилснаас 2-ыг олж тогтоон 11 үлдэгдэлтэй, аман зургаар 1 хүн эрэн сурвалжилж олж тогтоосон.

Эрэн сурвалжлах “ASAP” сангийн ашиглалт бүрдүүлэлтийг сайжруулах зорилгоор сангийн үйл ажиллагаанд тогтмол хяналт тавьж, эрэн сурвалжлагдаж байгаа хүн, мал, амьтан, эд зүйлийг хянах, бүртгэх эрх бүхий алба хаагч санд оруулсан мэдээллийг тухай бүр хянаж, бүртгэн, шаардлага хангаагүй мэдээлэл оруулсан алба хаагч нарт, мэдээллийг тэр даруй засаж оруулах талаар үүрэг чиглэл өгч, зөрчлийг тухай бүр засуулан ажилласан.

Шуурхай удирдлагын албаны чиглэлээр:Аймгийн хэмжээнд 2018 оны 1 дүгээр улиралд иргэд байгууллагаас гэмт хэргийн шинжтэй 86, зөрчлийн шинжтэй 641, нийт 727 дуудлага мэдээлэл хүлээн авч хэргийн газрын үзлэгийн багийг удирдан зохион байгуулж, тухай бүрт хойшлуулшгүй ажиллагааг шуурхай зохион байгуулж ажиллалаа.

Шуурхай удирдлагын албанд хөтлөгдвөл зохих бүртгэлүүдийг шинэчлэн тулгалт хийж, алба хаагчдад хариуцуулан өгч, ажил хүлээлцэхдээ албаны галт зэвсэг, цагдаагийн газрын эд зүйлийг нэг бүрчлэн нүд үзэн тулгаж, хүлээлцсэн тухай тэмдэглэл үйлдэн, цагдаагийн газрын хоногийн мэдээ, бүртгэлийн дэвтэрт бүртгэж, гэмт хэргийн шинжтэй мэдээ, мэдээллийг тухай бүрт цагдаагийн газрын удирдлагууд, Цагдаагийн ерөнхий газрын Шуурхай ажиллагааны хэлтэс, Эрүүгийн цагдаагийн алба, Мэдээлэл шуурхай удирдлагын төвд хүргүүлэн ажиллаж байна.

Ажил сайжруулах чиглэлээр удирдлагуудаас ирүүлсэн зааварчлагын дагуу жижүүрийн офицер, мэдээлэл хүлээн авагч нарт дүрэм, журам, зааварчилгыг хэрэгжүүлж ажиллах чиглэлээр сургалт зохион байгуулж, шинээр томилогдсон алба хаагчдыг сурган дадлагажуулж, үүрэг даалгаврыг заасан хугацаанд биелүүлэн, дүнг танилцуулж байна.

Цагдаагийн байгууллагын барилга байгууламжийг гадны гэмт халдлага, гэнэтийн аюул, осол байгалийн аюултай үзэгдэл, алба хаагчдын болгоомжгүй байдлаас үүсэж бий болох хор аюулаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, зорилгоор өрөө тасалгааны аюулгүй байдал нууцлалыг хангуулж, лац тэмдгийг тухай бүр хүлээлцэж, алба хаагчдын өрөөний нөөц түлхүүр болон албаны тээврийн хэрэгсэл, автогражуудын түлхүүрийг хийж хадгалах төмөр сейфийг шинээр авч ашиглаж байна.

2.2. Хэрэг бүртгэх тасгийн үйл ажиллагааны чиглэлээр:

Хэрэг бүртгэх тасаг нь аймгийн төвд тасгийн дарга, ахлах мөрдөгч, Мандал сум дахь сум дундын цагдаагийн хэлтэст ахлах мөрдөгчийн орон тоотой, мөн хэрэг бүртгэх эрх бүхий 19 алба хаагч ажиллаж байна.

Тус тасаг нь 2018 оны 1 дүгээр улиралд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжээс нийт 31 өргөдөл гомдол хүлээн авснаас 28 гомдолд нь хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хэрэг нээж, 2 гомдолд хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах санал гаргаж, одоо ажиллагаанд 1 гомдол байна.

Хэрэг бүртгэлтийн 41 хэрэг шалгаснаас 21 хэрэгт эрүүгийн хэрэг үүсгэн яллагдагчаар татаж, 2 хэргийг хаах саналтай прокурорт хүргүүлж, 1 хэргийг харъяаллын дагуу шилжүүлж, одоо ажиллагаанд 17 хэрэг бүртгэлтийн хэрэг байна.

Мөрдөн байцаалтын 25 хэрэг шалгаснаас 17 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай хүргүүлж, одоо ажиллагаанд 8 хэрэг байна.

Мөрдөн байцаах тасгаас хугацаа хэтэрсэн 3 /түдгэлзүүлсэн 2/ мөрдөн байцаалтын хэрэг хүлээн авч, 2 түдгэлзүүлсэн хэргийн эзэн холбогдогчийг олж тогтоон сэргээн шалгаж шийдвэрлэсэн байна.

Тасгийн даргын зүгээс түдгэлзүүлсэн болон, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын 10 хэрэгтэй уншиж танилцан, алба хаагчдад 3 зааварчилгаа, 2 даалгавар бичиж, 2 зааварчилгааны биелэлт тооцон ажилласан.

Иргэдэд учирсан 1,8 сая төгрөгийн хохирлоос хэрэг бүртгэлт мөрдөн байцаалтын шатанд 100% нөхөн төлүүлж ажилласан.

2.3.Мөрдөн байцаах тасгийн үйл ажиллагааны чиглэлээр:

Тус тасаг нь 2018 оны 1 дүгээр улиралд гэмт хэргийн шинжтэй 55 гомдол, мэдээлёийг хүлээн авснаас хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 30 буюу 56,6 хувь, эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан 13 буюу 23.6 хувь, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 10 буюу 18.1 хувь, харьяаллын дагуу шилжүүлсэн 2 буюу 3.6 хувийг тус тус шийдвэрлэж, гомдол мэдээллийн үлдэгдэлгүй байна.

Аймгийн төвд 88 холбогдогчтой, эрүүгийн 75 хэрэгт мөрдөн байцаалтын àæèëèàãàà ÿâóóёснаас 6 хэрэгт хугацаа сунгаж, нийт хэргийн 80 хувийг хуулийн анхны хугацаанд шийдвэрлэлээ.

Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан хэргээс ондоо түдгэлзүүлсэн /урьд оны дугаартай/ эрүүгийн 2 хэргийг түдгэлзүүлсэнийг сэргээн шалгаж, 1 хэргийг хэрэгсэхгүй болгож, 1 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай шилжүүлсэн.

Хэрэг бүртгэлтийн 36 холбогдогчтой 46 хэрэг шалгаснаас 12-г хэргийг хаах, 17-г эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах саналтайгаар прокурорт шилжүүлж, харьяаллын дагуу 7 хэргийг шилжүүлж, одоо ажиллагаанд 10 хэргийн үлдэгдэлтэй байгаа нь хэргийн шийдвэрлэлт 78.6 хувьтай байна.

Тайлангийн хугацаанд прокуророос 3, шүүхээс 1 хэрэг буцсан байгаа нь нийт шийдсэн хэргийн 6.0 хувийг эзэлж байна.

Гэмт хэргийн улмаас мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргүүдэд иргэд байгууллагад учирсан 41.9 сая төгрөгийн хохирол бүртгэгдсэнээс 32.4 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн нь хохирол нөхөн төлүүлэлт 77.3 хувьтай байна.

Иргэний нэхэмжлэл, торгох ял, эд хөрөнгө хураах байдлыг хангах зорилгоор иргэн, аж ахуй нэгж байгууллагын эзэмшлийн нийт 51.7 сая төгрөгийн үнэ бүхий эд хөрөнгийг битүүмжилсэн.

Мөрдөн байцаах тасагт ажиллагаанд шалгагдаж байгаа хэргийн шийдвэрлэх графикыг сар бүр гаргаж Аймгийн прокурор, Цагдаагийн газрын дарга нараар батлуулан гүйцэтгэлийг тооцож ажиллаж байна.

Урьд оны үлдэгдэл хэргүүдийг шийдвэрлэх, хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын хугацаа сунган шалгагдаж байгаа эрүүгийн хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх зорилгоор шүүх, прокуроруд болон мөрдөгч нарын өргөтгөсөн зөвлөгөөнийг 1 удаа

зохион байгуулж, цаашид хийж хэрэгжүүлэх, шийдвэрлэх хэргүүдийг ярилцаж шийдвэрлэв.

Тасгийн дарга, ахлах мөрдөгч нар мөрдөгч нарын хугацаа сунган шалгаж байгаа болон хүнд, хөнгөн гэмт хэргүүдийг илрүүлэх, хэргийг шийдвэрлүүлэхээр мөрдөн шалгах ажиллагаанд байгаа хэрэг нэг бүртэй танилцан хэрэг бүртгэлтийн 4, мөрдөн байцаалтын 15, нийт эрүүгийн 19 хэрэгт бичгээр зааварчилгаа өгч, үр дүнг тооцож ажиллалаа.

Тухайн улиралд цагдан хорих байранд яллагдагчаар нийт 6 хүнийг хорьж шалгаснаас 5 хүний хэргийг шийдвэрлэж, одоо 1 хүн цагдан хоригдон шалгагдаж байна.Хүнийг 1 сараас дээш хугацаагаар цагдан хорьж хэргийг шалгаагүй байна.

Шалгасан хэргийн шалтгаан нөхцлийг судалж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр шүүхэд шилжүүлэх саналтай шийдвэрлэсэн 66 хэргээс 64 хэрэгт мөрдөгчийн мэдэгдэл хүргүүлэн, хариуг авсан.

Цагдаагийн бусад газар, хэлтэст эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахаар мөрдөгчийн даалгавар 17-г хүргүүлж, хариуг 100 хувь авсны зэрэгцээ бусад газраас ирүүлсэн даалгавар бүрийг хугацаанд нь хүргүүллээ.

Эрүүгийн хэрэг үүсгэх үедээ сэжигтнээр тооцвол зохих этгээд нь тогтоогдоогүй хэргийг илрүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр тасаг, албадын ажлын уялдаа холбоог сайжруулах зорилгоор мөрдөгч, эрүүгийн мөрдөгч нарыг аймгийн хэмжээнд бүсэд хуваах, ахлах мөрдөгч нарт хуваарилан өгч, гэмт хэрэг үйлдэгдсэн үед хамтарсан багаар ажиллуулснаар бүртгэгдэх үедээ эзэн холбогдогч нь тогтоогдоогүй байсан хүнд, хөнгөн болон хэргийн илрүүлэлт 100 хувьтай байна.

Тухайн улиралд эзэн холбогдогч нь тогтоогдоогүй гэмт хэргийг илрүүлэх, оргон зайлсан гэмт этгээдийг эрэн сурвалжилан олж тогтоох, мэдээ, мэдээлэл цуглуулах чиглэлээр “Сар шинэ”, “Оргодол-1” “Шийдвэрлэлт” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион явуулж, эрэн сурвалжлагдаж байсан 4 хүнийг олж тогтоон, эрэн сурвалжлалтыг зогсоосон.

2.4.Замын цагдаагийн тасгийн үйл ажиллагааны чиглэлээр:

Аймгийн хэмжээнд 2018 оны 1 дүгээр улиралд хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 10, осол 4 үйлдэгдэж, хэргийн улмаас 4 хүн нас барж, 9 хүн гэмтсэн байна.

Тус тасгийн алба хаагчдаас эргүүл, хяналт шалгалтаар 4015 зөрчил илрүүлснээс согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон зөрчил 155, /үүнээс тээврийн хэрэгсэл жолоодох эрхээ хасуулсан үедээ 22, эрхийн үнэмлэхгүй согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон-8, жолоодох эрхийн үнэмлэхтэй согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон-125/, тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй 112, бусад зөрчлийн улмаас 3748, нийт 183.689.250 төгрөгөөр торгож шийдвэрлэсэн.

Тайлангийн хугацаанд төр, засгийн тэргүүн, бусад зочид төлөөлөгч, олон нийтийг хамарсан арга хэмжээний үеийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нийт 31 удаагийн хамгаалалтанд 128 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж, зөрчилд дутагдалгүй ажилласан.

Хөдөлгөөний аюулгүй байдал, тээврийн хэрэгслийн ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Сар шинэ-Аюулгүй тээвэр”, “Ачаа тээвэр” нэгдсэн арга хэмжээ, “Тээврийн хэрэгслийн гэрэлтүүлэг” “Нийтийн тээвэр”, “Авто засвар” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг зохион байгуулж, 2059 жолоочид ухуулга яриа таниулга хийж, 7 төрлийн 1500 ширхэг санамж, сэрэмжлүүлэг, ухуулга, сурталчилгааны материалыг тарааж, радио, телевизээр 6 удаа мэдээ, сэрэмжлүүлэг нэвтрүүлэн, “Сэлэнгэ Цагдаагийн газар”, “Орон нутгийн замын цагдаа” цахим хуудсанд давхардсан тоогоор 55 удаа мэдээ, сэрэмжлүүлэгийг байршуулан, олон нийтэд сурталчилсан байна.

Зам тээврийн î ñî ë, çº ð÷ëèéí ø àëòãààí í º õöëèéã àðèëãóëàõààð байгууллага аж ахуйн нэгжид давхардсан тоогоор 24 албан ì ýäýãäýë өгч, хариуг заасан хугацаанд авч үр дүнг тооцсон.Мэдэгдлийн дагуу аймгийн төвд байрлах “Сэлэнгэ олон улсын худалдааны төв”-ийн гадна талын авто зогсоолыг хянах 10 ширхэг хяналтын камерыг шинээр байрлуулж, стандартын шаардлага хангаагүй дараллын тэмдэг 2 ширхэг 6.12 тэмдэг шинээр сольж, Сүхбаатар-Алтанбулаг зам дагуу 58 ширхэг гэрлийг асаах зэрэг ажлуудыг зохион байгуулсан.

Мөн цагдаагийн газрын төв конторт байрлах Сүхбаатар сумын зам дагуу байрлуулсан эргэдэг 9, хөдөлгөөнгүй 20 камерыг засварлан хэвийн үйл ажиллагааг ханган ашиглалтанд оруулаа.

Зөрчлийн тухай хуулийн техник, замын хяналттай холбоотой заалтуудын дагуу нийт 2002 жолоочид 51.195.000 төгрөгийн торгуулийг оногдуулсан.

Тайлангийн хугацаанд 5 аж ахуйн нэгж байгууллагын 98 иргэн, ерөнхий боловсролын дунд сургуулийн 60 сурагч, цэцэрлэгийн 28 хүүхэд 6 багш нарт “Замын хөдөлгөөний дүрэм”, “Зөрчлийн тухай хууль”, “Хүүхдийн эрх ба хүмүүжил, төлөвшил” сэдвээр тус тус сургалтыг зохион байгуулж, санал, хүсэлтийг хүлээн авч ажиллалаа.

Àéì ãèéí õýì æýýí ä сóðãàëò зохион байгуулж буй 15 жолооны курсэд 241 иргэн суралцсанаас 231 нь шалгалтанд тэнцэж, 10 нь давтан сургалтанд хамрагдсан байна.

ЦЕГ-ын Бүртгэл хяналтын төвд тээврийн хэрэгсэл жолоодох эрх сэргээсэн 68, үнэмлэх нөхөн олгох 47, шинээр шалгалтанд тэнцсэн 231 жолоочийн материалыг тээврийн хэрэгсэл жолоодох эрх хасагдсан 128 жолоочийн мэдээллийн хамт хүргүүллээ.

2.5. Нийтийн хэв журам хамгаалах тасгийн үйл ажиллагааны чиглэлээр:

Тус тасгаас 2018 оны 1 дүгээр улиралд нийтийн хэв журам сахиулах эргүүлд давхардсан тоогоор 750 алба хаагч 4500 хүн/цагийн үүрэг гүйцэтгэж, Шуурхай удирдлаганаас ирүүлсэн 263 дуудлага мэдээллийг хүлээн авч, 59 иргэнийг албадан саатуулж, гудамж талбай олон нийтийн газарт согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэж бие авч явах чадваргүй 127 иргэнийг ар гэр, асран хамгаалах хүнд нь хүлээлгэн өгч, 144 тээврийн хэрэгсэл, 255 аж ахуйн нэгж, байгууллагын харуул манаа, 4 онц чухал объект, согтууруулах ундаа худалддаг түүгээр үйлчилдэг 843 баар кафе, хүнсний дэлгүүрийг тус тус шалгаж, эрэн сурвалжлагдсан 1 хүн, 3 тээврийн хэрэгсэл 3, 1 малыг тус тус илрүүлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 1628 иргэнд яриа таниулга хийж, 1743 санамж сэрэмжлүүлэг тарааж ажилласан байна.

Төр засгийн тэргүүн, бусад олон нийтийн арга хэмжээний үеийн хамгаалалтанд 4 удаа 208 алба хаагч, 18 тээврийн хэрэгсэл, 160 тусгай хэрэгсэл, 46 холбооны хэрэгсэлтэйгээр 1193 хүн/цагийн үүрэг гүйцэтгэлээ.

2018 оны 03 дугаар сард Ерөө сумын засаг даргын 78 тоот захирамжийг үндэслэн тус сумын нутаг дэвсгэрт орших “Өлөнт” гэх газарт байрлаж байсан хууль бус гар аргаар алт олборлож буй 170 гаруй иргэн, отог 31, гэр дэлгүүр 4 тус тус тарааж ажиллалаа.

Нэгдсэн болон хэсэгчилсэн арга хэмжээний талаар:Тайлангийн хугацаанд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр “Сэрэмжилье Нэгдье”, “Хуулиа мөрдье”, “Хуулийн хэрэгжилт” зэрэг нэгдсэн, “Хамтарсан шалгалт”, “Гэр хороолол 4,8”, “Иргэддээ сэрэмжлүүлье”, “Хулгайлах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлье”, “Эзэнгүй айл” зэрэг хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг хариуцсан нутаг дэвсгэрийн онцлогт тохируулсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулж, үр дүнг тооцсон бөгөөд одоо “Хуулийн хэрэгжилт” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулан ажиллаж байна.

Арга хэмжээнүүдийн хүрээнд Аймгийн Статистикийн хэлтэстэй хамтран барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгж, байгууллагын дарга эрхлэгч нарт 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн мөрдөгдөж байгаа “Барьцаалан зээлдүүлэх үйлчилгээний стандарт MNS:8574-2017”-ын талаар сургалт зохион байгуулж, хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр анхааруулга зөвлөмж өгч ажиллалаа.

Нэг бүрчилсэн арга хэмжээний талаар:Тус Цагдаагийн газраас шүүхээс тэнсэн харгалзах ялаар шийтгэгдсэн 93 иргэнд захиргааны хяналт тогтоож ажилласнаас 2018 оны 1 дүгээр улиралд шинээр 2 иргэнд захиргааны хяналт тогтоож, 23 иргэний захиргааны хяналтыг хугацаа дууссан үндэслэлээр зогсоож, 9 иргэний хяналтын хувийн хэргийг харьяаллын дагуу шилжүүлж, одоо нийт 53 иргэнд захиргааны хяналт тавин ажиллаж байна.

Хорих ялаас тэнсэн суллагдсан 22 иргэнд хяналт тавьж ажилласнаас тухайн улиралд 1 иргэнд захиргааны хяналт тогтоож, 13 иргэний захиргааны хяналтыг хугацаа дууссан үндэслэлээр зогсоож, одоо нийт 10 иргэнд захиргааны хяналт тавин ажиллаж байна.

Насанд хүрээгүй хүнд хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 2 иргэнд захиргааны хяналт тавьж, хяналтын хугацаа дууссан үндэслэлээр 2 иргэний захиргааны хяналтыг зогсоосон.

Жирэмсэн, 3 хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан 2, хорих ял эдлээд суллагдсан 3 иргэнд тус тус захиргааны хяналт тавих ажлыг зохион байгуулан ажиллаж байна.

Эрүүлжүүлэх, саатуулах байрны үйл ажиллагааны талаар:Тус цагдаагийн газрын эрүүлжүүлэх, саатуулах байранд 2018 оны 1 дүгээр улиралд аймгийн төвд 187, Мандал суманд 299, Сайхан суманд 60, нийт 546 хүнийг архидан согтуурсны улмаас саатуулж, 2.128.950 төгрөгийн төлбөрийг авч ажиллалаа.

Саатуулагдсан хүмүүсээс биеийн эрүүл мэндийн байдалд өөрчлөлт орсон 15 хүнд эмнэлгийн анхны тусламжийг үзүүлж, 3 хүнийг нэгдсэн эмнэлгийн 103 яаралтай тусламжинд үзүүлж хүлээлгэн өгч, тэдэнд тавих хяналтыг сайжруулж, архины хордлогонд орохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг тогтмол авч ажиллаж байна.

Зөрчлийн тухай хуулийн дагуу 16 хүнийг батлагдсан тогтоолыг үндэслэн хүлээн авч, зохих журмын дагуу бүртгэн хяналт тавьж ажилласан.

Шүүхийн шийтгэврээр баривчлагдсан 100 иргэнийг шийтгэвэр, холбогдох бичиг баримтын хамт хүлээн авч, Хууль зүйн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 29-ний өдрийн а/246 дугаар тушаалаар батлагдсан журмыг баримтлан ажиллаж байна.

Баривчлагдсан хүмүүст холбогдох хууль тогтоомж, журмуудаар мэдлэг олгох, архины хор уршгийн талаар таниулах, эрүүл мэндийн чиглэлээр мэдвэл зохих мэдлэгийг эзэмшүүлэх зорилгоор 27 удаа давхардсан тоогоор 170 хүнд сургалт зохион байгуулж ажилласан.

Зөвшөөрлийн системийн талаар:Тус цагдаагийн газраас 2018 оны 01 дүгээр улиралд 1 галт зэвсгийг гэрчилгээжүүлж, 2 галт зэвсгийн гэрчилгээг нөхөн олгож, төв орон нутгийн бусад Цагдаагийн газар, хэлтэст 3 галт зэвсгийн шилжилт хөдөлгөөнийг хийж ажиллалаа.

Гэмт хэрэг, зөрчлийн учир хураагдсан болон байгууллага, иргэдийн хүсэлтээр устгалд оруулахаар ирүүлсэн 47 галт зэвсэг, 1 галт зэвсэгтэй адилтгах хэрэгслийг тус тус хураан авч, Шүүхийн шинжилгээний Үндэсний Хүрээлэнд цаашид ашиглах боломжтой эсэх талаар дүгнэлт гаргуулахаар хүргүүлсэн.

Монгол улсын “Галт зэвсгийн тухай хууль”-ийг зөрчсөн 2 иргэнийг Зөрчлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 4,5 дахь хэсэгт зааснаар 40.000 төгрөгөөр тус тус торгож арга хэмжээ тооцлоо.

Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах талаар:2018 оны 1 дүгээр улиралд аймгийн төвд эрүүгийн 147, иргэний 139, захиргааны хэргийн 9, зөрчлийн 31, Мандал

сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн алба хаагчид эрүүгийн 90, иргэний 62, зөрчлийн 59, Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн алба хаагчид эрүүгийн 56, иргэний 38, зөрчлийн 16 хурал, нийт эрүүгийн 293, иргэний 239, зөрчлийн 106, захиргааны хэргийн 9, бүгд 647 шүүх хурал хуралдаж шүүх хуралд хамгаалалтыг зохион байгуулсан.

Шүүхийн байрнаас Цагдан хорих байранд 7 удаа 15 яллагдагч, шүүгдэгчийг нийт 55 удаа 63 яллагдагч, шүүгдэгчийг холбогдох хууль, журмын дагуу зөрчил дутагдалгүй хуяглан хүргэх ажиллагааг зохион байгуулж ажиллагааны явцад алба хаагчдын болон яллагдагч, шүүгдэгчийн аюулгүй байдлыг хангаж ажилласан.

Сэлэнгэ аймаг дахь Иргэний хэргийн анхан шатны шүүх, Мандал сум дахь сум дахь сум дундын Иргэний хэргийн анхан шатны шүүхээс албадан ирүүлэх 7 захирамж ирүүлсэнийг журмын дагуу шийдвэрлэж захирамжийн биелэлтийг хангасан.

Шүүхээс эрэн сурвалжлуулахаар даалгасан 19 иргэний захирамж, шийдвэр ирүүлсэнийг хүлээн авч 3 захирамжинд нэр дурьдагдсан иргэний хаяг байршлыг олж тогтоон урьд оны 6 захирамжийн биелэлтийг хангаж нийт 9 иргэний хаяг байршлыг олж тогтоож эрэн сурвалжлалтыг зогсоосон.

2.6.Захиргааны удирдлагын тасгийн үйл ажиллагааны чиглэлээр:

Тус тасгаас Цагдаагийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой үүрэг, äààëãàâàð, õº òº ëáº ð, Цагдаагийн ерөнхий газрын дарга, тэргүүн дэд, дэд дарга, бусад алба, газрын дарга нараас ирүүлсэн албан даалгавар, үүрэг, ажлын чиглэлийг нийт алба хаагчдад танилцуулж хэвшин, хэрэгжүүлэх ажлын салбар төлөвлөгөө гарган, биелэлтийг нэгтгэн үр дүнг тооцон ажиллаж байна.

Öàãäààãèéí åðº í õèé ãàçðûí äàðãûí òóøààë, º ãñº í ¿¿ðýã çº âëº ëèéí õóðàëäààí û ø èéäâýðèéã тухай бүр í èéò бие á¿ðýëäýõ¿¿í ä танилцуулж, дээд газраас ирүүлсэн мэдээлэл, үүрэг, ажлын чиглэлийг хэлтэс, тасаг хэсгүүдэд хүргүүлэн, õýðýãæ¿¿ëýõ ажлын төлөвлөгөөг гаргуулж, үүрэг чиглэл өгч, хэрэгжилтийг сар бүр дүгнэж ажиллалаа.

Цагдаагийн газар, хэлтэс, тасгийн хэмжээнд Монгол Улсын хууль тогтоомж, дээд байгууллага, албан тушаалтны болон удирдлагаас гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэх, түүний биелэлтэд хяналт тавьж, үр дүнг тооцох, алба хаагч ажилтныг сургаж бэлтгэх, дадлагажуулах, мэдлэг чадварыг дээшлүүлэх, тэдний дунд явуулах соён гэгээрүүлэх, сахилга, ёс зүйн ажлыг хариуцан, алба хаагчдын нийгмийн баталгаа, ажиллах нөхцлийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлэх ажилд бүх талын туслалцаа дэмжлэг үзүүлж ажиллаж байна.

Сэтгэл зүйчийн үйл ажиллагааны талаар:Алба хаагчдад өглөөний нэгдэлт эхлэхээс өмнө танин мэдэхүйн болон яруу найраг, дуу, хошин шог, сургамжит өгүүллэг гэх мэт хувь хүний төлөвшил, хандлагыг өөрчлөхөд эерэг түлхэц үзүүлэхүйц видео бичлэгийг үзүүлэн таниулж байна.

Цагдаагийн байгууллагаас дэвшүүлсэн зорилтын хүрээнд “Удирдах ухаан ба менежментийн орчин үеийн загварууд”, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код 912/ “Алба хаагчийн гадаад үзэмж биеэ авч явах байдал” сэдэвт сургалт, алба хаагчдад багаар ажиллах чадварыг хөгжүүлэх, ажлаас үүссэн стрессийн түвшинг бууруулах зорилгоор “Манжин” сэтгэл зүйн семинар/жүжигчилсэн тоглолтыг тус тус зохион байгуулсан.

Захиргааны удирдлагын тасгийн нийт 14 алба хаагчдад “Өөрийгөө танин мэдье” сэдвийн хүрээнд сэтгэл зүйн сорил авч, хамтран ярилцаж сэтгэл зүйн сургалтыг зохион байгуулсан.

“Зан үйлд нөлөөлөх албадан сургалт”-ын хөтөлбөрийн дагуу албадан сургалтыг зохион байгуулсан ажлын тайланг нэгтгэн Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц сургалтын хэлтэст хүргүүлэв.

70368111 нууцлалын кодтой алба хаагчтай ганцаарчлан уулзаж сэтгэл зүйн тандах ярилцлага зохион байгуулсан ба тухайн алба хаагчийн сэтгэл зүйн онцлогт тохируулан зөвлөн туслаж ажилласан.

Эрүүлжүүлэх, саатуулах байранд шүүгчийн шийтгэврээр баривчлагдсан иргэн Д.Баасанжавтай сэтгэл зүйн ганцаарчилсан ярилцлага хийж, сэтгэл зүйн сорил авч,сорилын тэмдэглэл, сэтгэл зүйн дүгнэлтийг гаргаж хариуцсан эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгөв.

Сахилга, ёс зүйн зөрчил гаргасан 3 алба хаагчтай ганцаарчлан уулзаж нас, сэтгэл зүйн онцлогт тохирсон зөвлөмж, зөвлөгөө өгч ажиллав.

ЦБҮАЖ код 938.6.4-д заасны дагуу цагдаагийн байгууллагад шинээр томилогдсон 1, хяналтын 1, нийт 2 алба хаагчтай ганцаарчлан уулзаж сэтгэл зүйн картанд баяжилт хийсэн.

Замын Цагдаагийн албанаас харъяа газар, хэлтсийн алба хаагчдын сахилга, ёс зүйг дээшлүүлэх чиглэлээр ирүүлсэн албан бичгийн дагуу тус цагдаагийн газрын замын цагдаагийн тасгийн 9 алба хаагчаас санал асуулга авч нэгтгэн боловсруулж, дүнг удирдлагад танилцуулав.

Цагдаагийн газрын даргаас өгсөн үүргийн дагуу харуул, жижүүрт 24 цагаар үүрэг гүйцэтгэж буй алба хаагчтай ганцаарчлан уулзаж, үүрэг гүйцэтгэхэд тулгамдаж буй хүндрэл бэрхшээлийг тодруулах, ажлын ачаалал, ажлаас үүсэх стрессийг түвшинг тогтоох зорилгоор нийт 12 алба хаагчтай уулзаж, дэвшүүлсэн саналыг нэгтгэн газрын удирдлагад танилцуулсан.

Сахилга, ёс зүйг сайжруулах чиглэлээр нийт 74 алба хаагчдаас санал асуулга авч дүнг нэгтгэн, шууд удирдах даргад танилцуулан ажиллав.

Төвөөс ирүүлсэн албан бичгийн дагуу Хууль сахиулахын их сургуулийг төгссөн ахлагч-20, офицер-11, удирдах албан тушаалтан-7, нийт 38 алба хаагчаас санал асуулга авч, дүнг нэгтгэж харьяалах газарт хариуг хүргүүлэв.

Цагдаагийн байгууллагад дахин орж ажиллах хүсэлт гаргасан Сайхан сумын иргэн Д.Ариунболдтой ганцаарчлан уулзаж тухайн албанд ажиллахад хувь хүний сэтгэл зүйн тохироц чанарыг хангаж байгаа эсэх талаар судалж, ярилцлагын тэмдэглэлийг хариуцсан эрх бүхий албан тушаалтанд хүлээлгэн өгөв.

Насанд хүрэгчдийн сэтгэл зүйн тогтвортой байдлыг судлах сэтгэл зүйн сорилыг хөрвүүлэн судалгааны санд баяжилт хийсэн.

2.7. Мандал сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн үйл ажиллагааны талаар:

Тус Цагдаагийн хэлтэс нь Цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2018 онд дэвшүүлсэн зорилтыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж, Цагдаагийн ерөнхий газрын даргаас Хууль зүй дотоод хэргийн сайдтай байгуулсан үр дүнгийн гэрээ, Цагдаагийн газрын даргаас Цагдаагийн ерөнхий газрын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ, Цагдаагийн ерөнхий газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөө болон үүрэг, ажлын чиглэл, албан даалгаврыг удирдлага болгон салбар төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг ханган ажиллав.

Тухайн улиралд Цагдаагийн хэлтсийн даргын зөвлөл 7 удаа хуралдаж, 39 асуудал хэлэлцэн шийдвэрлэж, алба хаагчдын ажлын үр дүнг дүгнэсэн-2, ажлын хэсэг байгуулах-4, дадлагажуулан сургагч томилох-1, сахилгын шийтгэл ногдуулах-4, бусад-10, нийт хэлтсийн даргын 21 тушаалыг батлан гаргаж хэрэгжүүлсэн байна.

Цагдаагийн ерөнхий газрын Хүний нөөц сургалтын хэлтсээс ирүүлсэн ажлын чиглэлийн дагуу тус хэлтсийн сул орон тоонд 6 иргэнийг судалж, сонгон шалгаруулалтанд оролцуулснаас 2 иргэн тэнцсэн байна.

Тус хэлтсээс 1 алба хаагчийг албан тушаал дэвшүүлэхээр, 3 алба хаагчийг цагдаагийн хугацааны цол олгуулахаар, 2 алба хаагчийг өөрийн хүсэлтээр албанаас чөлөөлүүлэхээр, ахлагч бүрэлдэхүүнээс нэр бүхий 3 алба хаагчийн ажлын байрыг өөрчлөх, саналыг аймгийн Цагдаагийн газарт уламжлан шийдвэрлүүлэв.

Монгол улсын Цагдаагийн албаны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь хэсгийн хэрэгжилтийг хангах, Цагдаагийн хэлтсийн 2017 оны үйл ажиллагааны тайланг иргэдэд хүргэх, Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг сурталчилах, иргэдэд хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, санал хүсэлтийг нь хүлээн авах зорилгоор “Иргэдээ сонсоё” арга хэмжээг энэ оны 02 дугаар сарын 02-ны өдөр “Мөнгөн хараа” дуу бүжгийн чуулгад зохион байгууллаа.

Хэлтсийн түүхт 60 жилийн ойг угтаж байгууллагын гадна болон дотор засвар үйлчилгээг хийх төсөв, хөрөнгийн тооцоог гарган Сэлэнгэ аймгийн Засаг дарга, орон нутгийн удирдлагад хүргүүлээд байна.

Цагдаагийн хэлтсийн даргын №12 дугаар тушаалаар архивын бичиг баримтанд боловсруулалт хийх ажлын хэсэг байгуулж хэлтсийн нийт алба хаагчдыг татан оролцуулж, архивын бичиг баримтанд боловсруулалт хийж цэгцлэв.

Мандал сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлийн “2018 оны Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө”-г боловсруулан батлуулж, Монгол Улсын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 19 дүгээр заалтыг хэрэгжүүлэх үүднээс гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулагдах 23 сая төгрөгийг Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар шийдвэрлүүлэв.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын дарга О.Алтансүх, Сэлэнгэ аймгийн Засаг дарга Ш.Оргил нарт тус Цагдаагийн хэлтсийн хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээнд үйлдэгдсэн гэр бүлийн хүчирхийллийн болон хүүхдээс үйлдсэн гэмт хэргийн нөхцөл байдлын судалгаа, “Түр хамгаалах байр” байгуулах төслийг 2018 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн 50/2-15, 16 дугаартай албан бичгээр хүргүүлж шийдвэрлүүлсэн.

Иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, цагдаагийн байгууллагатай хамтран ажиллах, аюулгүй амар тайван орчинд ажиллах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор хэлтсийн алба хаагчдад аж ахуй нэгж, байгууллагуудыг хариуцуулан өгч давхардсан тоогоор нийт 120 аж ахуй нэгж, байгууллагын 1856 ажилтан, алба хаагч нарт “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх”, “Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” зэрэг яриа, таниулга хийж, тэднээс санал, асуулга авч, гарсан саналын дагуу төлөвлөгөө боловсруулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

<u>Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр:</u>Эзэн холбогдогч нь тогтоогдоогүй хулгайлах гэмт хэргүүдийг илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр “Хулгай-2018” хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, алба хаагчдыг хамтарсан багаар ажиллуулж , үр дүнг тооцлоо.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран энэ оны 02 дугаар сарын 03-ний өдөр “Мөнгөн хараа” дуу бүжгийн чуулганд “Малчдын зөвлөгөөн”-ийг зохион байгуулж ажилласан.

<u>Мөрдөн байцаах албаны чиглэлээр:</u> Тус тасаг нь 2018 оны 1 дүгээр улиралд ãýì òõýðãèéí ø èí æòýé 36 ãî ì äол, мэдээлёийг хүлээн авснаас хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн 5 буюу 13,8 хувь, эрүүгийн хэрэг үүсгэж, яллагдагчаар татсан 22 буюу 61,1 хувь, хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан 5 буюу 13,8 хувь, харьяаллын дагуу шилжүүлсэн 2 буюу 5,5 хувийг тус тус шийдвэрлэж, одоо ажиллагаанд 2 гомдол мэдээлэл шалгагдаж байна.

Аймгийн төвд 42 холбогдогчтой, эрүүгийн 59 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулснаас 5 хэрэгт хугацаа сунгаж, нийт хэргийн 74,5 хувийг хуулийн анхны хугацаанд шийдвэрлэлээ.

Мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан хэргээс 23 хэргийг хэрэгсэхгүй болгож, 16 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай шилжүүлсэн.

Хэрэг бүртгэлтийн 7 холбогдогчтой 23 хэрэг шалгаснаас 23-г хэргийг хаах, 17-г

Тайлангийн хугацаанд шүүхээс 1 хэрэг буцсан байгаа нь нийт шийдсэн хэргийн 1,6 хувийг эзэлж байна.

Гэмт хэргийн улмаас мөрдөн шалгах ажиллагаа явуулсан хэргүүдэд иргэд байгууллагад учирсан 5.9 сая төгрөгийн хохирол бүртгэгдсэнээс 5.3 сая төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн нь хохирол нөхөн төлүүлэлт 89.8 хувьтай байна.

Иргэний нэхэмжлэл, торгох ял, эд хөрөнгө хураах байдлыг хангах зорилгоор иргэн, аж ахуй нэгж байгууллагын эзэмшлийн эд хөрөнгийг битүүмжлээгүй байна.

Энэ оны 01 дүгээр сарын 26-ны өдөр Цагдаагийн хэлтэс нь сум дундын Прокурорын газартай хамтарсан зөвлөгөөн зохион байгуулсан. Уг зөвлөгөөнөөр 2017 оны ажлыг дүгнэж, 2018 онд ЭХТА-ийн 17.1 “Хулгайлах” гэмт хэрэг гарч буй шалтгаан, нөхцлийг судалж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хамтран зохион байгуулах, мөрдөн байцаалтын хугацаа сунгахгүй байхын тулд хөнгөн хэрэгт 10 хоног, хүнд хэрэгт 25 хоног мөрдөн байцаалт явуулж, прокурорын хяналтад ирүүлж байхаар тогтсон.

<u>Нийтийн хэв журам хамгаалах чиглэлээр:</u> Хэсгийн даргаас хэсгийн байцаагч, багийн цагдаа нарын болон эрүүлжүүлэх саатуулах байр, эргүүлийн үүрэг гүйцэтгэлт, ажлын тэмдэглэл хөтлөлт зэрэгт өдөр тутам биечлэн танилцаж, хүлээлцүүлэн, өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг тухай бүрт нь тооцож ажиллав.

Тодорхой төрлийн гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх зорилгоор “Сэрэмжилье-Нэгдье”, “Хуулиа-Мөрдье-21”, “Сар шинэ-Аюулгүй тээвэр”, “Хулгай-2018”, “Сар шинэ-2018”, “Хуулийн хэрэгжилт”, “Ачааны автомашиы бүрэн бүтэн байдал ачаа тээвэрлэлт”, “Дотуур байр” зэрэг нэгдсэн -5, хэсэгчилсэн -3 арга хэмжээг тус тус төлөвлөгөөний дагуу зохион байгуулан, үр дүнг тооцон ажиллаж байна. Тухайлбал:

“Сэрэмжилье-Нэгдье” нэгдсэн арга хэмжээний хүрээнд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудад хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх санамж, сэрэмжлүүлгийг 150 ширхэг тараан өгч, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар яриа, таниулга хийж, архидан согтуурахаас урьдчилан сэргийлэх үүднээс аж ахуй нэгж, байгууллагад “Архигүй хамт олон” уриалга тараан өгсөн.

“Сар шинэ-2018” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд баярын өдрүүдэд байгууллагынхаа аюулгүй байдлыг ханган ажиллах хариуцлагатай эргүүл томилох тухай мэдэгдэл бичин хариуг хугацаанд нь авч ажилласан.

“Хуулийн хэрэгжилт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд согтууруулах ундаа хэрэглэхээс урьдчилан сэргийлэх, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх санамж, сэрэмжлүүлгийг 150 ширхэгийг иргэд олноор цуглардаг газруудад байршуулж ажилласан.

“Сэрэмжилье-Нэгдье”, “Хуулиа-Мөрдье-21” нэгдсэн арга хэмжээний хүрээнд цагдаагийн хэлтсийн бие бүрэлдэхүүн нэгдсэн журмаар энэ оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн 18:30-22:00 цагийн хооронд эргүүлийн үүрэг гүйцэтгэн ажилласан. Ажиллах хугацаанд баар, кафе-4, дэлгүүр, мухлаг-119, тээврийн хэрэгсэл-183, энгийн харуул манаа-9, Шатахуун түгээх станц-12-г шалгаж, зохих зөвшөөрөлгүй тамхи худалдсан 1 зөрчил илрүүлж, бэлэн бус торгуулийн машинаар 7 иргэнийг 180.000 төгрөгөөр торгосон. Мөн ахмад Б.Мөнхцэцэг Мандал сумын мэргэжлийн хяналтын улсын байцаагч М.Болормаагийн хамт согтууруулах ундаа худалддаг болон түүгээр үйлчилдэг 29 аж ахуй нэгжүүдэд хяналт, шалгалт хийж, “Хуулиа-Мөрдье-21” зурагт хуудсыг тараан өгч ажилласан.

Мандал сумын хэмжээнд үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, илрүүлэх, иргэдийн аюулгүй амар тайван ажиллаж, амьдрах нөхцөл бололцоог бүрдүүлэх, нийтийн хэв журмыг хамгаалах үүднээс аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн оролцоотой "Олон нийтийн эргүүл ажиллуулах тухай" Мандал сумын Засаг даргын 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 20 тоот захирамжыг энэ оны 02 дугаар сарын 05-ны өдрөөс эхлэн хэрэгжүүлэн ажиллаж байна.

Насанд хүрээгүй хүүхдээс үйлдэгдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:Энэ оны 1 дүгээр сарын 26, 30, 31-ний өдрүүдэд Сэлэнгэ аймгийн Мандал сумын ерөнхий боловсролын 1, 3, Билиг ДБ сургуулиудын 8-12 дугаар ангийн 37 бүлгийн 646 сурагчдад "Хүүхдийг гэмт хэргээс урьчдилан сэргийлье" сэдэвт сургалтыг 38 цагдаагийн алба хаагч зохион байгуулан ажилласан байна.

Энэ улиралд Ерөнхий боловсролын 8 сургуульд 416, 9 цэцэрлэгт 351, нийт 17 байгууллагад 1067 эцэг эх "School Police" эцэг, эхийн эргүүлд ажилласан байна.

Мөн Ерөнхий боловсролын сургууль 8, цэцэрлэг 9, нийт 17 байгууллагын "School Police" эцэг, эхийн эргүүлийн үйл ажиллагааг давхардсан тоогоор 8 удаа шалгаж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллаа.

Хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:Хариуцсан нутаг дэвсгэрт 2018 оны 01 дүгээр улиралд зам тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдал, ашиглалтын журмын эсрэг гэмт хэрэг 2 бүртгэгдсэнээс 2 хүн нас барж, 1 хүн гэмтсэн байна.

Энэ оны 01 дүгээр улиралын байдлаар замын цагдаагийн алба хаагчид нийт 2094 зөрчил илрүүлснээс согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодож замын хөдөлгөөнд оролцсон 83 жолоочийг илрүүлснээс эрхийн үнэмлэхгүй, эрхгүй үедээ согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 16 хүнийг шүүхээр баривчлуулан, тээврийн хэрэгслийг түр саатуулах байранд 95 тээврийн хэрэгслийг журамлаж гарч болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлж ажилласан.

Зөрчил гаргасан 2078 жолоочийг холбогдох заалтаар 61.792.250 төгрөгийн торгууль оногдуулж хариуцлага тооцсон. Үүнээс: Зөрчлийн тухай хуулийн 14.7.3.1 заалтаар 83 жолоочийг 33.200.000 төгрөг, 14.7.1 заалтаар 80 жолоочийг 16.000.000 төгрөгийн торгууль оногдуулж хариуцлага тооцсон байна.

Зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх, орон нутгийн авто замд тавих хяналтыг сайжруулах, хөдөлгөөнд оролцогч нарын сахилга соёлыг дээшлүүлэх чиглэлээр "Сар шинэ-Аюулгүй тээвэр" нэгдсэн арга хэмжээний хүрээнд замын цагдаагийн алба хаагчид хариуцсан нутаг дэвсгэртээ хяналт шалгалтыг зохион байгуулан ажиллаж байна. Мөн тээврийн хэрэгслийн жолооч нарт согтууруулах ундаа хэрэглэж, замын хөдөлгөөнд оролцохгүй байх талаар санамж, сэрэмжлүүлэг тараан өгсөн.

Мөн 1 дүгээр улирлын байдлаар нэгдсэн болон хэсэгчилсэн хяналт, шалгалт анд нийт 6 удаа ажилласан байна. Мандал сумын нутагт мал, амьтаны А зэрэглэлийн шүлхий өвчин гарсантай холбогдуулж хорио цээрийн бүс тогтоож тус сумын хэмжээнд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний түр хугацаагаар хорьж, алба хаагчид хорио цэрийн 8 цэгт хяналт шалгалт хийж хамгаалалтанд гарч ажилласан.

Замын цагдаагийн албаны Техник, замын хяналтын хэлтсийн даргын 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн 13-5/752 дугаартай "Ачааны автомашины бүрэн бүтэн байдал ачаа тээвэрлэлт" нэгдсэн арга хэмжээг хариуцсан нутаг дэвсгэрт зохион явуулан ажиллаж байна. Үүнд:

Улаанбаатар- Дархан-Уул аймгийн чиглэлийн орон нутгийн чанартай замаар ачаа тээвэрлэж байгаа ачааны авто машинуудын бүрэн бүтэн байдалд хяналт тавьж илэрсэн зөрчил дутагдалыг арилгуулж, илэрсэн зөрчилд арга хэмжээ тооцов.

Цагдаагийн хэлтсээс санаачлан Мандал суманд үйл ажиллагаа явуулдаг авто сургуулиудтай хамтран замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль болон

замын хөдөлгөөний дүрмийн хэрэгжилтийг хангах, зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор “Сайн жолооч” арга хэмжээг 2018 оны 02 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан.

Арга хэмжээний хүрээнд тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хяналт тавьж, замын хөдөлгөөнд соёлтой оролцсон иргэн Г.Мөнхсүхэд гарын бэлэг гардуулав.

Мөн таксины үйлчилгээ эрхэлдэг жолооч нарын дунд “Замын хөдөлгөөний дүрэм”-ийн мэдлэгийг сорих асуулт, хариултын тэмцээн зохион байгуулж, амжилттай оролцсон жолооч Б.Баясгаланд “Таархал”, гарын бэлгийг гардуулж өгсөн.

Олон нийтийн аюулгүй байдлыг хангах чиглэлээр:Сэлэнгэ аймгийн Мандал сумын 7 багт оршин суух иргэн Балдангомбын Даваагийн 1 тооны үхэрт 2017.11.16-ний өдөр малын гоц халдварт “Шүлхий” өвчний шинж тэмдэг илэрч уг өвчний эх үүсвэр, дэгдэлт, гаралт, тархалтын шалтгааныг нарийвчлан шалгаж тогтоох зорилгоор тус сумын Засаг даргын 2017 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 405 тоот “Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай”, 2017 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн 407 тоот “Хорио цээрийн дэглэм тогтоох тухай”, 408 тоот “Өвчтэй малыг устгалд оруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн томилох тухай”, 414 тоот “Золбин нохой устгалд оруулах тухай” захирамжуудыг гаргаж, хэрэгжилтийг хангах зорилгоор 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийг хүртэлх хугацаанд доорх ажлуудыг зохион байгуулан ажилласан байна.

Онцгой нөхцөл байдал үүссэн үед ажиллах төлөвлөгөөний дагуу үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдад аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч, Мандал сумын нутаг дэвсгэрт сумын тамгын газар, Онцгой байдлын газартай хамтран 24 цагаар Мандал сумаас Улаанбаатар хот, Баянгол сум, Ерөө сум, Дархан-уул аймгийн Шарын гол сум, Төв аймгийн Батсүмбэр сумын чиглэл рүү явах гол замуудад 9 цэгт байнгын хяналтын пост, сумын төвд 4 чиглэлд хөдөлгөөнт эргүүлийг ажиллуулсан. Мандал сумаас 4218 тээврийн хэрэгсэл, 5287 иргэн гарч, 5436 тээврийн хэрэгсэл, 6658 иргэн нэвтрэн орох үед үзлэг, шалгалт хийж ариутгасан.

Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга нь 2018 оны 02 дугаар сарын 22-ны өдөр Мандал суманд ажлын айлчлал хийх үеийн хэв журмын хамгаалалтанд тус цагдаагийн хэлтсийн 28 офицер, 33 ахлагч, нийт 61 алба хаагч, 6 тээврийн хэрэгсэлтэйгээр хэв журам сахиулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалт зохицуулалтыг төлөвлөгөө, зураглалын дагуу зохион байгуулсан. Ерөнхийлөгчийн хамгаалалт, зохицуулалтын үед Төрийн тусгай хамгаалалтын алба, Сэлэнгэ аймгийн Тагнуулын газар, сумын Онцгой байдлын хэлтсийн алба хаагч нартай мэдээлэл солилцон хамтран ажилласан.

Цагдаагийн бэлтгэл ахлах ахлагч Г.Жаргалбатын нэрэмжит Сэлэнгэ аймгийн автомашин, мотоцикль сонирхогчдын дунд “Хараагийн хавар” бартаат замын автомашины уралдааны үеийн хэв журам, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалтанд тус цагдаагийн хэлтсийн 4 офицер, 10 ахлагч, нийт 14 алба хаагч, 2 тээврийн хэрэгсэлтэйгээр хэв журам сахиулах, замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах хамгаалалт зохицуулалтыг төлөвлөгөө, зураглалын дагуу зохион байгуулсан.

Бартаат замын автомашины уралдаанд нийт 36 тээврийн хэрэгсэл уралдсан бөгөөд 400 гаруй тээврийн хэрэгсэл, 1600 орчим иргэд уг уралдааныг үзэж сонирхохоор ирсэн байлаа.

Сахилга хариуцлага, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх болон авлигаас сэргийлэх ажлын талаар:Сахилга, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн хэлтсийн “Сахилгын зөвлөгөөн”-ийг энэ оны 03 дугаар сард зохион байгуулж, сахилгын зөрчил гарган арга хэмжээ авагдсан 5 алба хаагчдад зөвлөмж хүргүүлж, нийт алба хаагчдаас сахилга, ёс зүйн зөрчил, дутагдал гаргахгүй ажиллах талаар бичгээр 2 удаа баталгаа гаргуулав.

Сум дундын ерөнхий прокуророос 1 шаардлагыг хүлээн авч шалтгаан нөхцлийг тогтоож зөрчлийг арилгуулж хариуг хүргүүлэв.

Тус Цагдаагийн хэлтсээс 2018 онд зохион байгуулах албаны хичээл сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулж 12 сэдвээр 10 цагийн хичээл сургалтыг алба хаагчдын дунд зохион байгуулав.

Энэ оны 03 дугаар сарын 09-ны өдөр Засаг даргын тамгын газрын Иргэний танхимд зохион байгуулагдсан “Удирдах ажилтны зөвлөгөөн”-д тус цагдаагийн хэлтсээс “Гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн байгууллагуудын оролцоо” сэдвээр мэдээлэл хийж ажилласан.

Хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг худалдаа үйлчилгээний газар болон баар, ресторан, зоогийн газруудын захирал, эрхлэгч нарыг оролцуулсан “Үйлчилгээний салбарын зөвлөгөөн”-д оролцож, тэдний санал хүсэлтийг хүлээн авч, “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд аж ахуй нэгжийн оролцоо” сэдвээр мэдээлэл хийж, орон нутгийн “Мандал” телевизэд мэдээ, мэдээлэл хийн ажилласан.

Тус хэлтсийн соён гэрэлгүүлэх ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Нийтийн хэв журам хамгаалах хэсгээс хэлтсийн аварга шалгаруулах “Сагсан бөмбөг”-ийн тэмцээн, “Дээлтэй монгол” тэмцээнүүдийг зохион байгуулсан.

Үндэсний аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий байгууллагуудын алба хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх зорилгоор “Марш тактик тусгай бэлтгэл-2018” аварга шалгаруулах тэмцээнд тус хэлтсийн баг тамирчид “Дэд” байранд шалгарсан.

Орон нутгийн “Мандал” телевизтэй хамтран 7 хоног бүрийн “Мягмар” гарагт эрүү хэв журам, гэмт хэрэг, зөрчлийн талаар тухай бүр мэдээлэл хийж ажилласан. Мөн Цагдаагийн хэлтсийн “Сум дундын цагдаагийн хэлтэс” Facebook сайтанд нийт 32 мэдээ, мэдээлэлийг байршуулж иргэн, олон нийтэд хүргэсэн байна.

Алба хаагч, ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг хангах, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:Алба хаагчдын ажиллах нөхцөл боломжийг сайжруулах зорилгоор Цагдаагийн ерөнхий газрын Санхүү аж ахуйн албанаас 3 ширхэг иж бүрэн компьютерийг шийдвэрлүүлэн үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Мөн хэлтсийн 2 алба хаагч, 4 ахмад ажилтныг нөхөн сэргээх “Сүүж” сувилалд эмчлүүлэхээр захиалга өгсөн.

Энэ оны 02 дугаар сарын 04-ний өдөр Цагдаагийн хэлтсийн ахмад ажилтануудыг хүлээн авч уулзаж, тэдний санал, хүсэлтийг нь сонсож ажиллаа.

Мандал сумын “Бату” өрхийн эмнэлэгтэй хамтарч алба хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг болон сахарын шинжилгээнд хамруулсан.

Дотоод хяналтын хүрээнд: Цагдаагийн байгууллагын дотоод аюулгүй байдлыг хангах журам /код-113/-ыг хэрэгжүүлэх чиглэлээр төлөвлөгөө боловсруулан батлуулж, хэлтсийн алба хаагчдад мэдээллийн болон албаны тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг хангах, албаны баримт бичгийн аюулгүй байдлыг хамгаалах чиглэлээр 2 цагийн хичээл сургалтыг зохион байгуулсан.

Алба хаагчдын аюулгүй байдлыг хангах чиглэлээр алба хаагчдаас согтуурулах ундааны зүйл хэрэглэхгүй байх, албаны бэлэн байдлыг хангаж ажиллах, Цагдаагийн албаны тухай хууль болон сахилга, ёс зүйн дүрмийг хэрэгжүүлэх, ажлын сахилга, хариуцлагыг сайжруулах талаар нийт 5 төрлийн баталгааг бичгээр авч хэрэгжилтэд нь хяналт тавин ажилласан.

Энэ оны 1 дүгээр улиралд цагдаагийн алба хаагчийн сахилга, ёс зүйн дүрэм журам зөрчсөн гэх үндэслэлээр 10 алба хаагчид холбогдуулан Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам /код-112/-т зааснаар албаны шалгалт явуулж 5 алба хаагчид сахилгын шийтгэл оногдуулсан.

Цагдаагийн хэлтэст ашиглагдаж байгаа албаны тээврийн хэрэгслийн аюулгүй байдал, тээврийн хэрэгсэл эзэмшиж буй алба хаагч нарын мэдлэг ур чадвар,

тээврийн хэрэгсэл жолоодох эрх, ангилал зэрэгт 2018 оны 02 дугаар сарын 27-ны өдөр үзлэг, шалгалт хийж, илэрсэн зөрчлийг арилгуулсан.

2.8. Сайхан сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн үйл ажиллагааны чиглэлээр:

Тус цагдаагийн хэлтэс нь Цагдаагийн ерөнхий газраас дэвшүүлсэн зорилго, зорилтыг хангуулах, дээд байгууллагаас ирүүлсэн тушаал, шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг ажлын чиглэлийг хангуулах зорилгоор 2018 онд хийж гүйцэтгэх ажлаа жил, улирлаар төлөвлөн, үр дүнг тооцон ажиллаж байна.

Тухайн улиралд цагдаагийн хэлтсийн даргын зөвлөл 6 удаа хуралдаж төлөвлөгөөний дагуу хэлэлцэх 21 асуудлыг бүрэн хэлэлцэн шийдвэрлэж ажиллалаа.Зөвлөлийн хурлаас хэлтсийн даргын А/14, Б/8 нийт 22 тушаал гарч бие бүрэлдэхүүнд танилцуулан үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Сар бүр алба хаагчдын ажлын үр дүнг хэлэлцэн давхардсан тоогоор 17 алба хаагчийн сарын үндсэн цалинг 10-20 хувиар нэмж, 14 алба хаагчийн сарын үндсэн цалинг 5-20 хувиар хасч олгосон байна.

Дээд шатны байгууллага, бусад газар хэлтсээс нийт ирүүлсэн 525 албан бичиг, тушаал, шийдвэр, хөтөлбөр, төлөвлөгөө, үүрэг, чиглэлийг бие бүрэлдэхүүнд танилцуулан бүртгэж, 282 албан бичгийн хариуг заагдсан хугацаанд холбогдох газарт хүргүүлсэн байна.

Монголын үндэсний баяр цагаан сар “Арван долдугаар жарны Тийн унжлагат хэмээх шороон нохой жилийн сар шинийн баяр”-ыг тохиолдуулан тус цагдаагийн хэлтсээс цэргийн байнгын тэтгэвэрт гарсан 16 ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлэх, гарын бэлэг гардуулах ажил, арга хэмжээг 2018 оны 02 дугаар сарын 13-ны өдөр, алба хаагчдын золголтын арга хэмжээг 2018 оны 02 дугаар сарын 18-ны өдөр, нохой жилийн шинийн арван дөрөвний билэгт сайн өдөр буюу 2018 оны 03 дугаар сарын 02-ны өдөр цагдаагийн хэлтсийн бие бүрэлдэхүүн ажил үйлсээ даатгаж, ном уншуулах, даллага авахуулах арга хэмжээг тус тус цагдаагийн хэлтэс дээр зохион байгуулав.

Алба хаагчдын ажиллах нөхцөл бололцоог сайжруулах зорилгоор сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарыг Сайхан суманд ажиллах үед тэднийг хоноглох байр, мөн албан томилолтоор яваа алба хаагчдыг байршуулах өрөө тасалгааг өөрсдийн нөөц бололцоонд тулгуурлан хэлтсийн хашаан дотор байх нийтийн байрыг засч ашиглалтанд оруулсан. Уг байранд мөн хэлтсийн цайны газрыг шилжүүлэн нүүлгэж, хуучин цайны газар байсан өрөөг иргэдийн хүлээлгийн болон “Алдрын” танхим болгон тохижуулахаар бэлтгэл ажлыг хангаж байна.

Алба хаагчдаас байгууллагын удирдлагад хандан гаргасан 28 өргөдөл хүсэлтийг хүлээн авч тухай бүр шийдвэрлэн, өргөдөл гаргагчид хариуг өгч ажиллаж байна.

***Эрүүгийн цагдаагийн албаны чиглэлээр*:**Тус цагдаагийн хэлтсийн эрүүгийн цагдаагийн хэсгийн алба хаагчид 2018 оны 1 дүгээр улиралд улиралд гэмт хэргийн гомдол мэдээлэл 9-ийг хүлээн авч хуулийн хугацаанд шалгасан.Нууц далд аргаар үйлдэгдсэн 16,950,000 төгрөгийн хохиролтой, 22 холбогдогчтой, 9 хэрэг бүртгэлтийн хэргийн эзэн холбогдогчийг олж тогтоон яллагдагчаар татаж хэргийг шүүхэд шилжүүлж ажилласан.

Зөрчлийн шинжтэй гомдол, мэдээлэл 15-ыг шалгаж, 6 хэрэг нээж, 4 хялбаршуулан, 5 гомдол мэдээллийг татгалзаж, 2 хүнийг баривчлуулж, 3 хүнийг торгож ажилласан.

“Эрэн сурвалжлах ASAP сан”-д оруулсан мэдээллийг төрлөөр нь үзвэл:Алга болсон хүн-3, Хэн болох нь тогтоогдохгүй цогцос- 1, Эд зүйл- 5, Мал амьтан-0, Галт зэвсэг- 1 тус тус зарласан байна.

Сэлэнгэ аймгийн баруун таван сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа гэмт халдлагад өртөж болзошгүй бэлэн мөнгө ихээр төвлөрдөг банк, дэлгүүр, шатахуун түгээх станцуудыг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх чиглэлээр шалгаж, ГХУСАХ мэргэжилтнээр мэдэгдэл бичүүлж, камержуулж, эргүүлийн үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдаар 7 хоногт 2-оос доошгүй удаа шалгуулж ажилласан.

Сумдын хэсгийн төлөөлөгч нарт сум орон нутагтаа хулгайлах, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх таслан зогсоох чиглэлээр мэдээ, мэдээлэл цуглуулан нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, газар байдлыг тогтоож, эргүүл шалгалтыг хийх үүрэг өгсөний дагуу хэсгийн төлөөлөгч, эрүүгийн мөрдөгч нар 3 удаа хөдөлгөөнт эргүүлийг хийсэн.

“Сар шинэ 2018” нэгдсэн арга хэмжээний хүрээнд баруун таван сумын хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа гэмт халдлагад өртөж болзошгүй бэлэн мөнгө ихээр төвлөрдөг банк, дэлгүүр, шатахуун түгээх станцуудыг гэмт халдлагаас урьдчилан сэргийлэх чиглэлээр шалгаж үүрэгжүүлэн ажилласан.

Хулгайлах, мал хулгайлах гэмт хэрэг ихээр гарч байгаа Дархан-уул аймагтай хөрш залгаа оршдог “Ширээ нуруу”, “Салхит, “Номгон”, “Хавцал” зэрэг газарт хөдөлгөөнт эргүүлийг 4 удаа 23-09 цаг хүртэлх хугацаанд явуулж ажиллалаа.

Сэлэнгэ аймгийн Орхон сумын ЗДТГ-тай хамтран хулгайлах, мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор малчдын зөвлөгөөнийг 2 дугаар сард эрүүгийн мөрдөгч, мөрдөгч, ГХУС байцаагч, хэсгийн мөрдөгч нарыг оролцуулан зохион байгуулан “Нөхөрлөл” нэртэй малчдын бүлгэмийг байгуулж ажилласан.

Мөрдөн байцаах албаны чиглэлээр:Тайлангийн хугацаанд иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас гэмт хэргийн шинжтэй өргөдөл гомдол нийт 30 гэмт хэргийн шинжтэй гомдол хүлээн авч шалгасан нь урд оны мөн үеэс 3.0 хувиар өссөн. Үүнээс 50 хувь буюу 15 материалд хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн. 13.3 хувь буюу 4 материалыг шууд эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татсан. 33.3 хувь буюу 10 материалыг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 3.3 хувь буюу 1 материалыг харъяаллын дагуу шилжүүлж шийдвэрлэсэн.

Нийт 28 холбогдогчтой 19 хэрэгт мөрдөн байцаалтын ажиллагаа явуулсан байх ба шалгасан хэргийн 68.4 хувь буюу 14 холбогдогчтой 13 хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорын хяналтанд шилжүүлж, ажиллагаанд үлдэгдэл мөрдөн байцаалтын 10 холбогдогчтой 6 буюу 46.1 хувь хэрэг байгаа нь мөрдсөн хэргийн шийдвэрлэлт 68.4 хувьтай байна.

Энэ хугацаанд гэмт хэрэг холбогдон шалгасан 5 хүнд цагдан хорих таслан сэрийглэх арга хэмжээ авч, Эрүүгийн цагдаагийн албанд 3, бусад газарт хэлтэст 4 даалгавар бичиж, бусад цагдаагийн газар хэлтэсээс мөрдөн байцаагчийн даалгавар 8-г хүлээн авч 8 даалгаварын хариуг заасан хугацаанд бүрэн хийж гүйцэтгэж хүргүүлсэн.

Гэмт хэргийн шалтгаан нөхцөлийг арилгуулах зорилгоор иргэн, аж ахуй нэгж байгуулагад 13 мэдэгдэл 8 мэдэгдлийн харуг авч газар дээр нь мэдэгдлийн мөрөөр хийсэн үйл ажиллагааг шалгаж ажилласан.

Гэмт хэргийн улмаас иргэд, аж ахуй нэгж албан байгууллагад 21.994.928 төгрөгийн хохирол учирсан бүртгэгдэж, 16.884.928 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн нь 76.7 хувьтай байна.

Хэрэг бүртгэх албаны чиглэлээр:Тайлангийн хугацаанд эхний 3 сарын байдлаар иргэн, аж ахуй нэгж, байгууллагаас гэмт хэргийн шинжтэй гомдол, мэдээлэл нийт 16–ийг хүлээн авч шалгаснаас 6 гомдолд хэрэг бүртгэлтийн хэрэг нээж хэрэг бүртгэлтийн гомдол мэдээллийн үлдэгдэлгүй байна.

Мөрдөн байцаах албанаас харьяаллын дагуу 1 хэрэг хүлээн авч нийт 7 хэрэгт хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулсанаас эрүүгийн хэргийг шүүхэд шилжүүлэх саналтай прокурорт 4 хэргийг шилжүүлж, одоо хэрэг бүртгэлтийн 3 хэргийн үлдэгдэлтэй байна.

Нийтийн хэв журам хамгаалах албаны чиглэлээр:Тус Цагдаагийн хэлтсийн нийтийн хэв журам хамгаалах хэсэг нь 2018 оны 1 дүгээр улиралд харьяалах нутаг дэвсгэрийн хэмжээнд Монгол Улсын Үндсэн хууль, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хууль, Цагдаагийн албаны тухай хууль, Зөрчлийн тухай, зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, УИХ, Засгийн газраас баталсан тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр гаргасан үндэсний хөтөлбөрүүд, цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стандартыг мөрдөн эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд үнэлэлт өгч, гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд төрийн болон төрийн бус байгууллагуудыг татан оролцуулахад ажлаа чиглүүлж ажиллалаа.

Цагдаагийн байгууллагад иргэдийн итгэх итгэл, дэмжлэгийг авах олон нийтийн оролцоонд түшиглэсэн хамтын ажиллагааг бэхжүүлэх, цагдаагийн байгууллага, алба хаагчийг сурталчилах ажлын хүрээнд Сайхан сумын орон нутгийн иргэдэд Цагдаагийн хэлтсийн үйл ажиллагааны тайланг тавьсан тухай мэдээллийг орон нутгийн “Эрдэнэ” телевизээр мэдээ, мэдээлэл хүргэн ажилласан.

Цагдаагийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсгийн 14.1.2, 14.2 дахь хэсэгт заасны дагуу Цагдаагийн хэлтсийн даргын зөвлөлийн гишүүдээр ахлуулсан ажлын хэсэг батлагдсан хуваарийн дагуу харъяа нутаг дэвсгэрийн Баруун таван сум, Номгон тосгоны оршин суугчдад 2017 онд хийж гүйцэтгэсэн үйл ажиллагааны тайланг бэлтгэн танилцуулах ажлыг 2018 оны 01 дүгээр сарын 16-ний өдрөөс 18-ны өдрийн хугацаанд зохион байгуулав.

Тайлан тавих хугацаанд иргэдээс цагдаагийн байгуулагын үйл ажиллагааны өнөөгийн байдал, цагдаагийн алба хаагчийн ёс зүйн асуудал, үйлчилгээний чанар шийдвэрлэх арга замыг тодорхойлох зорилго бүхий “Цагдаагийн байгуулагын өнөөдөр ба маргааш” гэсэн судалгааг түүврийн аргаар нийт 418 иргэдээс санал асуулгыг авч түүнд тоон ба чанарын дүгнэлтийг нягтлан дүгнэж холбогдох ажил арга хэмжээг зохион байгуулж ажилласан.

“Нийтийн эргүүл ажиллуулах тухай” №161 тоот Захирамжийн хэрэгжилтийг хангаж тус суманд үйл ажиллагаа явуулдаг байгууллага, аж ахуйн нэгжийг хуваарийн дагуу нийтийн эргүүлд ажиллуулж, иргэдийг мэргэжлийн удирдлагаар ханган хамтран ажиллаж байна. 2018 оны 01 дүгээр сард 24 аж ахуй нэгжийн 158 ажилтан цагдаагийн хэлтсийн 25 алба хаагчийн хамт 10 чиглэлд 20:00 цагаас 02:00 цагийн хооронд эргүүл, шалгалтыг хийж ажилласан.

Иргэдийн хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажилд аж ахуй нэгж, байгууллагуудыг татан оролцуулах арга хэмжээг сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөл, сум дундын прокурор, мэргэжлийн хяналтын тасагтай хамтран 2018 оны 01 дүгээр сарын 15-ний өдрөөс эхлэн 1 сарын хугацаатай зохион байгуулан ажиллаж байна.

Орхон аймгийн Жаргалант суманд малын гоц халдварт “шүлхий” өвчин гарсан тул урьдчилан сэргийлэх зорилгоор Сэлэнгэ аймгийн Баруунбүрэн сумын нутаг дэвсгэрт ариутгалын постыг 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн сумын тамгын газартай хамтран зохион байгуулж ажиллаж байна.

Замын цагдаагийн албаны чиглэлээр:Замын цагдаагийн алба нь Цагдаагийн Ерөнхий газраас дэвшүүлсэн зорилтын хүрээнд 2018 оны 1 дүгээр улиралд иргэд аж ахуйн нэгж байгууллагаас зам тээврийн осол, хэргийн мэдээлэлгүй, зөрчлийн дуудлага мэдээлэл хүлээн 37 авч шалгаснаас зөрчлийн хэрэг нээж шалгасан 12, хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн 27, гомдол мэдээлэл хүлээж аваахаас татгалзсан 2, үлдэгдэл 1 зөрчлийн хэрэг шалгагдаж байна.

Эргүүл, хяналт шалгалтын үүрэг гүйцэтгэх хугацаанд 647 çº ð÷èë èëð¿¿ëñí ýýñ Монгол улсын Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 3.1 дэхь хэсэгт заасан согтуугаар тээврийн хэрэгсэл жолоодсон 20 жолоочийг тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жил хугацаагаар хасаж, тус бүрийг нь 400.000 төгрөгөөр торгож, мөн

Монгол улсын Зөрчлийн тухай хуулийн 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан архи согтууруулах ундааны зүйл хэрэглэсэн үедээ эрхийн ¿нэмлэхг¿й, ангилал бус тээврийн хэрэгсэл жолоодсон 6 жолоочийг илрүүлэн Сайхан сум дахь сум дундын шүүхийн шүүгчээр тус бүрийг нь 07-20 хоногийн хугацаагаар баривчлууж, мөн эрхийн үнэмлэхгүй тээврийн хэрэгсэл жолоодож явсан 7 жолоочийг тус бүрийг нь 200.000 төгрөгөөр торгож арга хэмжээ авсан байна.

Гудамж талбай, замд эргүүл шалгалт хийж нийт 647 зөрчил илрүүлэн бэлэн бус торгуулийн системээр 508 жолоочийг 12.393.000 төгрөгөөр торгож торгуулийн арга хэмжээ тооцсон байна.

Сэлэнгэ аймгийн Сайхан суманд “Ачааны автомашин, ачаа тээвэрлэлт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан ажил арга хэмжээг ард олон нийтэд сурталчилах зорилгоор нэвтрүүлэг-1, шторк-1 бэлтгэн орон нутгийн “Эрдэнэ” кабелийн телевизээр сурталчилан ажиллалаа.

Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:Сайхан сумын Засаг даргын тамгын газрын Иргэний танхимд “Гэр бүлийн хүчирхийллийн тухай ойлголт, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд орсон 10 гол өөрчлөлт” сэдвээр сургалт зохион байгуулж 19 ажилтан хамрагдав.

“Хүүхдийн эрх үүрэг ба хариуцлага” сургалтыг 2018 оны 02 дугаар сарын 07-ны өдөр Сайхан сумын ерөнхий боловсролын сургууль дээр зохион байгуулж сургалтанд тус сургуулийн 8-12-р ангийн нийт 384 сурагч, 16 багш нар хамрагдав.Сургалтанд сум дундын цагдаагийн хэлтэс, сум дундын прокурорын газар, сум дундын шүүх, Засаг даргын тамгын газраас нийт 16 ажилтан, албан хаагч оролцож, нэг цаг хугацаанд 16 бүлэгт эрх зүйн сургалтыг хамтран зохион байгуулж байгаа онцлогтой юм.

Хууль хяналтын байгууллагын ажилтан, алба хаагчдын хар тамхи, мансууруулах бодисын талаарх ойлголт, хор хөнөөлийн талаар мэдлэгийг дээшлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр алба хаагчдыг чадваржуулах, хуулийн байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулах “Хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ, өнөөгийн нөхцөл байдал” сургалтыг 2018 оны 02 дугаар сарын 05-ны өдөр Сайхан сумын Засаг даргын тамгын газрын Иргэний танхимд зохион байгуулав.

Хар тамхи, мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн, доктор, професор Л.Лхагвасүрэн “Хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ, өнөөгийн нөхцөл байдал” сэдвээр хичээл зааж, Сайхан сум дахь цагдаагийн хэлтэс, сум дундын прокурорын газар, Сайхан сумын ЗДТГ-ын ажилтнууд нийт 31 албан хаагчид хамрагдан орон нутгийн Эрдэнэ телевизээр мэдээлэл хийж, 60 ширхэг гарын авлага, материал тараав.

“Өсвөр үеийг мансуурлаас сэргийлье” сургалтыг Сайхан сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд Хар тамхи, мансууруулах бодисоос иргэдийг хамгаалах нийгэмлэгийн тэргүүн, доктор професор Л.Лхагвасүрэнтэй хамтран зохион байгуулж, сурагчдын нэгдсэн оролцооны зөвлөлийн 40 сурагч, 3 багш хамрагдав.

Сайхан сумын ерөнхий боловсролын сургуулийн англи хэлний багш, магистр Х.Цэвээнсүрэнтэй хамтран “Итгэлийн галыг аавууд асаадаг” сургалтыг 2018 оны 03 дугаар сарын 01-ны өдөр цагдаагийн хэлтсийн алба хаагчдын дунд зохион байгуулж, алба хаагчдаас судалгаа авсан дүнг танилцуулж, сонирхсон асуултанд хариулав.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх, алба хаагчдад гэр бүлийн хүчирхийллийн шинжтэй дуудлага, мэдээллийг хүлээн авах ажиллагаанд хандах хандлагыг өөрчлөх зорилгоор 2018 оны 01 дүгээр сарын 24-ны өдөр алба хаагчдын дунд цагдаагийн хэлтсийн хурлын танхимд сургалтын ажлыг зохион байгуулав.

Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч 15 хүнд аюулын зэргийн үнэлгээ хийснээс 2 өндөр, 7 дунд, 6 бага түвшинд үнэлэгдсэн ба төрөл садан, ойр дотны хүний

хамгаалалтанд 12 хүнийг хүлээлгэн өгч, 15 хүнд эрх үүрэг, үзүүлэх үйлчилгээний талаар мэдээлэл өгөх “Тусламжийн хуудас” гардуулан ажиллав.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн зүйл заалт, цагдаагийн байгууллага алба хаагчийн үүргийг тайлбарлан таниулах сургалтыг зохион байгуулж 64 алба хаагч хамрагдав.

Урьдчилан сэргийлэх ажлын чиглэлээр:Хариуцсан сумдын хэмжээнд согтууруулах ундаа худалдан борлуулдаг түүгээр үйлчилдэг цэгүүд болох 48 аж ахуй нэгжүүдэд, эргүүлүүд болон, мэргэжлийн хяналтын байгууллагуудтай хамтран өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж ажилласан.

Мөн гэмт хэрэг, зөрчил үйлдэгдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор иргэд олон нийтэд яриа таниулга хийж, архидан согтуурах, хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, тодорхой төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр банк, ломбард, шатахуун түгээх станц, эмнэлэг, сургууль болон орон сууцны орцны үүдэнд” Сар шинэ”, “Сэрэмжилье-нэгдье”,”Хуулиа мөрдье-21” арга хэмжээний хүрээнд нийт 650 ширхэг санамж, сэрэмжлүүлгийг тараан байрлуулж ажилласан. 26 аж ахуйн нэгж байгууллагуудад камержуулалт, орчны аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах талаар 2 удаа албан мэдэгдлийг хугацаа заан хүргүүлж ажил арга хэмжээ зохион байгуулахыг мэдэгдэж ажиллаа.

Сум орон нутгийн гудамж талбайг камержуулах саналыг засаг дарга болон, ИТХ-д хүргүүлсэн.

Эрүү хэв журмын нөхцөл байдалтай уялдуулан 22 аж ахуйн нэгж албан байгууллагаас ГХУСАЗЗ-тэй хамтран сар бүр өдөрт 3-4 хүний бүрэлдэхүүнтэй нийтийн эргүүлд гарган, мэргэжлийн удирдлагаар ханган хамтран ажилласан.Томоохон үйлдвэр үйлчилгээний 7 газраас авто машинт хөдөлгөөнт эргүүлийг 24 цагаар 7 хоног ажиллуулсан.

Захиргааны хяналтанд байгаа 15 иргэдэд гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр Цагдаагийн хэлтсийн дарга, албадын ахлахууд, сум дундын прокурорын газрын хяналтын прокурор, сумдын багийн дарга нар, нийгмийн ажилтан, хэсгийн төлөөлөгч нарыг оролцуулан сургалт, сурталчилгааг 1 удаа зохион байгуулж, эдгээр хүмүүсийг дахин гэмт хэрэг зөрчилд өртүүлэхгүй байх тал дээр анхаарч хараа хяналтаа тал бүрээс нь сайжруулж байх талаар ярилцан, санал хүсэлтийг авч, хяналтанд буй иргэдээ тест бөглүүлж, Монгол Улсын “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай “, “Зөрчлийн тухай хууль”-иудаар сургалт орсон.

Хууль хяналтын байгууллагууд Сайхан сумын ЕББДС-д 2017.2.11 нд “Хүүхдийн хүмүүжил, төлөвшил”, “Хүүхдийг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлье”,“Хар тамхи мансууруулах бодисын хор хөнөөлөөс урьдчилан сэргийлье” нэртэй сургалтыг 9-12 дугаар ангийн 350 гаруй хүүхдэд орж гарын авлага, тараах материал 4 төрлийн 500 ширхэгийг тараан ажилласан.“Хуулиа мөрдье-21” арга хэмжээний хүрээнд Сэлэнгэ аймгийн баруун таван сумын хэмжээнд салбар төлөвлөгөө боловсруулан хүргүүлж, аж ахуйн нэгжүүдтэй хамтран хяналт шалгалт хийн үр дүнг тооцож ажилласан.

Цагдаагийн хэлтсийн алба хаагчдын хариуцсан 24 аж ахуйн нэгжүүдэд нь сар бүр шинээр гарсан хууль эрх зүйн актуудаар сургалтыг хийлгэж байна.

Хуулийн хэрэгжилт нэгдсэн арга хэмжээний салбар төлөвлөгөөг хариуцсан сумдад хүргүүлж, ажил арга хэмжээ зохион байгуулж ажиллаж байна.

Улсын Ерөнхий Прокурор, аймгийн Прокурорын газраас ирүүлсэн Насанд хүрээгүй хүн болон жирэмсэн эх, 3 хүртэлх хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан, Шүүхээс тэнсэн суллагдсан, хорих ангиас тэнсэн суллагдсан иргэнд хяналт тавих ажлын удирдамжын дагуу аймгийн болон сум дундын Прокурорын газраас төлөвлөгөөт шалгалтуудыг 2 удаа хийсэн.

Цагдаагийн хэлтсийн алба хаагчдыг тус сумдын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 87 албан байгууллага, аж ахуйн нэгжүүдэд гэмт хэргээс урьдчилан

сэргийлэх чиглэлээр яриа таниулга хийж, гарын авлага, санамж, сэрэмжлүүлэг, зөвлөмж 316 ширхэгийг хэвлүүлэн тарааж ажилласан.

Сэлэнгэ аймгийн Сайхан сумаар дайран өнгөрч буй тээврийн хэрэгслийн жолооч болон зорчигч нарт зам тээврийн осол хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 600 хүнд ухуулга яриа хийж, 4 төрлийн 600 ширхэг зурагт хуудас санамж сэрэмжлүүлэг тараан ажилласан.

Сайхан суманд үйл ажиллагаа явуулдаг “Эрдэнэ” КаТВ-ээр зам тээврийн осол, хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 3 удаа яриа хийж, 4 төрлийн санамж сэрэмжлүүлэг, зурагт хуудас 980 ширхэгийг тараан хууль эрх зүйн зөвлөгөө өгсөн.

Байгууллагын аюулгүй байдал, нууц хадгалалт, хамгаалалт, алба хаагчдын ажлын хариуцлага, сонор сэрэмж, саатуулах байрны үйл ажиллагаа, түүнд тавих хяналтыг чангатгаж, алба хаагчдын үүрэг гүйцэтгэлд тогтмол хяналт тавьж ажиллав.

Сахилга хариуцлага, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх болон авлигаас урьдчилан сэргийлэх ажлын талаар:Алба хаагчдыг сахилга ёс зүйн зөрчил дутагдал гаргахаас урьдчилан сэргийлж сахилга хариуцлагын зөрчил дутагдал гаргахгүй байх, согтуурулах ундаа хэрэглэсэн үедээ тээврийн хэрэгсэл жолоодохгүй байх зэрэг баталгаануудыг нийт алба хаагчдаар 3 удаа гаргуулан авч, 5 удаа зааварчилгаа өгч биелэлтийг тооцон ажиллаж байна.

Тайлангийн хугацаанд алба хаагчдыг хөгжүүлэх чиглэлээр даваа гарагийн өглөө бүр танин мэдэхүйн мэдээ, мэдээлэл, мэдвэл зохих хууль тогтоомжийн чиглэлээр 8 удаагийн 9 цагийн, мэргэжлийн ур чадварын болон дадлагажуулах чиглэлээр 5 удаагийн 6 цагийн сургалтыг зохион байгуулж, бие бялдрыг хөгжүүлэх чиглэлээр 12 удаагийн 32 цагийн сургалтанд хэлтсийн бие бүрэлдэхүүн бүрэн хамрагдсан.

Сайхан сумын Засаг даргын тамгын газраас санаачилсан “Авилгагүй, Тамхигүй, Архигүй, орчин” аяны хүрээнд 6 дахь жилдээ зохион байгуулагдаж байгаа төр төсвийн ААНБайгуулгуудын дунд зохион байгуулсан спортын 4 төрөлт тэмцээн уралдаанд идэвхитэй оролцож багийн нийлбэр дүнгээр “Тэргүүн байр”-ыг эзэлсэн.

Сэлэнгэ аймгийн сайхан сум дахь сум дундын цагдаагийн хэлтсийн дарга, цагдаагийн дэд хурандаа Б.Энхчулууны 2018 оны 3 дугаар сарын 02-ны өдөр баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2018 оны 3 дугаар сарын 08-ны өдөр “Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр”-ийг тохиолдуулан хэлтсийн эмэгтэйчүүдэд хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг тараан ажиллав.

2018 оны 03 дугаар сарын 08-ны өдөр Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөр тус Цагдаагийн хэлтсийн замын цагдаагийн алба хаагч нар санаачлан Сайхан сумынхаа жолооч, зорчигч бүсгүйчүүддээ 50 ширхэг улаан сарнай цэцэгт мэндчилгээ хүргэж орон нутгийн Эрдэнэ телевизтэй хамтран ажиллаа.

Монгол Цэргийн баяр, Зэвсэгт хүчний 97 жилийн ойн баярын өдрийг тохиолдуулан Сайхан сумын нийт аж ахуйн байгууллагуудын дунд зохион байгуулагсан “Эр хүн танаа” тэмцээнд алба хаагчдыг бүрэн хамруулж амжилттай оролцон.

Сайхан сумын засаг даргын тамгын газраас 2018 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр зохион байгуулсан “Цасны баяр”-ын “Буухиа, Уулын оргил, дартс”-ийн тэмцээн уралдаанд алба хаагчдыг бүрэн хамруулж амжилттай оролцсон.

Цагдаагийн хэлтсийн эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран алба хаагчдад “Талархалын өдөр”-ийг зохион байгуулж, халуун кофе, жигнэмэгээр дайлж “Гэр бүлийн аз жаргал” сэдэвт лекц уншсан.

Цагдаагийн хэлтсийн зүгээс иргэд, олон нийттэй хамтран зохион байгуулсан ажил, арга хэмжээний талаар болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн “Эрдэнэ” телевизээр нийт 10 удаа мэдээ мэдээлэл, 4 төрлийн шторкыг нэвтрүүлж олон нийтэд сурталчилж ажилласан.

“Эрдэнэ” КаТв-ээс зохион байгуулсан “ТВ-караоке” дууны тэмцээн Шүүх, шүүгчийн аюулгүй байдлыг хангах ажил хариуцсан байцаагч, цагдаагийн дэслэгч Б.Анхбаяр, Номгон тосгоны хэсгийн цагдаа, цагдаагийн ахлагч Ю.Баяржаргал, Орхон сумын хэсгийн цагдаа, цагдаагийн дэд ахлагч Д.Бямбасүрэн нар идэвхи санаачлагатай оролцож “Тэргүүн байр”-ыг эзэлсэн.

2.9.Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, малын хулгайлах гэмт хэрэг, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр: Цагдаагийн газрын даргын 2018 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн 06 дугаар тушаалаар гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд тасаг, албадын оролцоог нэмэгдүүлэх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор “Хэвлэл мэдээлэл, урьдчилан сэргийлэх ажлын хэсэг”-ийг тасаг бүрээс нэг алба хаагчийг оролцуулан Захигааны удирдлагын тасгийн даргын удирдлаган дор 7 хүний бүрэлдэхүүнтэй байгууллаа.

Аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлд 2018 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр зохион байгуулах 17 төрлийн заалт бүхий саналыг боловсруулан хүргүүлж, тус зөвлөлөөс энэ онд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөнд нь тусгуулав.

Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох чиглэлээр улсын хэмжээнд зохион байгуулсан “Сэрэмжилье-Нэгдье”, “Хуулиа мөрдье-21” нэгдсэн арга хэмжээнүүдийн хүрээнд тодорхой ажлуудыг зохион байгуулж, биелэлтийг Урьдчилан сургийлэх хэлтэст тухай бүр нь хүргүүлэв.

“Сэрэмжилье-Нэгдье” сурталчилгааны самбар, хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх санамж, сэрэмжлүүлгийг бэлтгэн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдэд тарааж, байгууллага, аж ахуйн нэгж хариуцсан алба хаагчид өөрсдийн хариуцсан байгууллага, аж ахуйн нэгж дээр биечлэн очиж, “Сар шинийн баярын үед гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх”, “Хулгайн гэмт хэргээс сэргийлэх” чиглэлээр яриа таниулга хийв.

Нийт 155 байгууллага, аж ахуйн нэгжид алба хаагч нар очиж “Сэрэмжилье-Нэгдье” аянд нэгдүүлж, Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн пейж хуудсанд байршуулсан хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Бүх гэр бүлд зориулав”, “Хайрла, хамгаал” аяны 2 төрлийн, “Ломбарданд хулгайлагдсан эд зүйл”, “Хулгайн зүйл мэдсээр байж ашиглавал”, “Хулгайн гэмт хэрэг” зэрэг 3 төрлийн шторк, бусад мэдээллийг орон нутгийн “Минй Монгол энтертаймент, “Таны Сэлэнгэ” “Мандал” телевиз болон “Сум дундын цагдаагийн хэлтэс”-ийн пэйж хуудсаар иргэн, олон нийтэд сурталчилан иргэдэд хүргэж ажилласан.

Мөн Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн оюутнууд болон Ерөнхий боловсролын сургуулиудын сурагчдын дунд хулгайн гэмт хэргээс урьчилан сэргийлэх талаар яриа таниулга хийж, мөн шторк, видео сэрэмжлүүлгүүдийг үзүүлэн хүргэж, “Сэрэмжилье-Нэгдье” аянд нэгдүүлэв.

Тээврийн хэрэгслийн хучилга алдагдахаас урьдчилан сэргийлэх зорилгоор Сүхбаатар сумын хэмжээнд “Хучлага” тусгай арга хэмжээг зохион байгуулж, ил задгай зогсоолд тавиатай байгаа тээврийн хэрэгслийн хучилга алдагдахаас урьдчилан сэргийлж, санамж сэрэмжлүүлгийн хуудсыг тээврийн хэрэгслийнх нь шил арчигчинд хавчуулах, жолооч нарт тараах, зөвлөгөө өгөх зэрэг ажиллагааг зохион байгуулсан.

Сүхбаатар сумын хэмжээнд хувийн автомашинаараа такси үйлчилгээ эрхэлдэг иргэдийг Цагдаагийн газарт цуглуулан “Хулгайн гэмт хэргээс сэргийлэх нь”, “Архидан согтуурахын хор уршиг”, “Оноо тооцох журам” сэдвүүдээр сургалтыг зохион байгуулж, “Сэрэмжилье-Нэгдье” арга хэмжээнд нэгдүүлэв.

Тус аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй барьцаалан зээлдүүлэх газрууд нь MNS 5274-2017 стандартын шаардлагыг хангаж буй эсэхэд хяналт шалгалтыг хийж, нийт 17 аж ахуйн нэгжийн барьцаалан зээлдүүлэх газрыг хамруулж, тэдгээр барьцаалан зээлдүүлэх газруудад хулгайн эд зүйл авахгүй байх талаар санамж, зөвлөгөмжийг хүргүүлж баталгаа аван, зохион байгуулсан ажлын дүнг судалгааны хамт 2018 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Урьдчилан сэргийлэх хэлтэст хүргүүллээ.

Хулгайлах төрлийн гэмт хэргийг аймаг сум дамжин үйлддэг сэжигтэй этгээдүүдийн талаар төв, орон нутгийн цагдаагийн газар, хэлтсийн эрүүгийн мөрдөгч нартай fecebook цахим хуудасны тусгай цахим групп хаягаар дамжуулан харилцан мэдээ, мэдээлэл солилцон ажиллаж байна.

Зохион байгуулсан ажил болон Цагдаагийн ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх хэлтсийн пейж хуудсанд тавигдсан хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх шторк, бусад мэдээллийг татан авч, Цагдаагийн газрын болон орон нутгийн “Сэлэнгэ Гхусаззөвлөл” цахим хаяг, “Сэлэнгэ цагдаа” фейсбүүк, тус цагдаагийн газрын пейж хуудас, сумдын цахим хаягуудад тус тус байршуулан иргэдэд сурталчилан хүргэлээ.

Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, иргэд, олон нийт, хүүхэд, залуучуудын дунд архины хор уршгийг сурталчлах зорилгоор зохион байгуулсан “Хуулиа мөрдье-21” нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газартай хамтран аймгийн хэмжээнд зохион байгуулах хамтарсан төлөвлөгөөг болон тус Цагдаагийн газрын зүгээс хийж гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг тус тус боловсруулан гаргаж, дээрх байгууллагуудын холбогдох албан тушаалтнуудтай хамтарсан зөвлөгөөнийг хийв.

Зөвлөгөөнөөс “Архины аюулаас ирээдүй хойч үеэ хамгаалцгаая” гэсэн уриалгыг гаргаж, сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл болон байгууллагуудад зөвлөмж, “21 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа худалдахыг хориглоно” гэсэн зурагт хуудсуудын хамт, сумдын хэсгийн мөрдөгч нарт уг арга хэмжээний хүрээнд зохион байгуулах ажлын чиглэлийг 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр бичгээр тус тус хүргүүллээ.

Цагдаагийн газраас “Хүний эрхийг дээдлэн хуулиа мөрдөж, амар тайван амьдралын төлөө хамтдаа”, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас “Эрсдэлгүй ирээдүйн төлөө хамтдаа”, Сайхан сумаас “Архигүй орчин бидний гэрэлт ирээдүй”, “Архигүй орчин гэр бүлийн аз жаргал” зэрэг уриалгыг дэвшүүлэн байгууллага, аж ахуйн нэгжид хүргүүлэв.

Цагдаагийн газрын алба хаагчдыг офицер, ахлагч гэсэн 2 хүний бүрэлдэхүүнтэй ажиллах багийг томилон хуваарилж, хуваарийн дагуу байгууллага, аж ахуйн нэгжид “Хуулиа мөрдье-21” арга хэмжээг сурталчлах, тухайн байгууллага, аж ахуйн нэгжид архидан согтуурахтай тэмцэх талаар тодорхой ажлуудыг зохион байгуулах мэдэгдэл өгөх, аймгийн “Архидалттай тэмцэх хөтөлбөр”-ийг сурталчлах , архины хор уршгийн талаар яриа таниулга хийх ажлыг зохион байгуулж, нийт 263 байгууллага, аж ахуйн нэгжийн 2181 ажилтан, алба хаагч, оюутан, сурагчдыг хамруулсан.

Аймгийн төвд үйл ажиллагаа явуулдаг, согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгжүүдийн эзэд, захирлуудыг цуглуулан хэлэлцүүлэг зохион байгуулж, “Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль”-аар сургалт зохион байгуулан “Архины аюулаас ирээдүй хойч үеэ хамгаалцгаая” уриалгад нэгдүүллээ.

Архины хэрэглээнээс татгалзуулах зорилго бүхий “Архи амьдралын дайсан”, “Танд амьдрал хэрэгтэй юу? Архи хэрэгтэй юу?” зэрэг 10 төрлийн онч мэргэн үгсийг бэлтгэж, хувилан согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг нийт 261 аж ахуйн нэгжүүдэд, хүний нүдэнд харагдахуйц газарт байршуулсан.

Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын алба хаагч, сумдын нийгмийн ажилтан нартай хамтран ерөнхий боловсролын сургуулиудын 8-12 дугаар ангийн сурагчдын дунд "Согтууруулах ундааны хор уршиг" сэдвээр сургалтыг зохион байгуулж, 24 сургуулийн 1458 сурагчийг, Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн 3 төвийн 214 хамруулан оролцуулав.

Замын Цагдаагийн тасгаас "Хуулиа мөрдье-21" арга хэмжээний хүрээнд "Гэрэл, гэрэлтүүлэг", "Нийтийн тээвэр" хэсэгчилсэн арга хэмжээг зохион байгуулж, Алтанбулаг-Сүхбаатар, Сүхбаатар-Дархан чиглэлийн шугам замд хяналт шалгалтыг хийлээ.

"Нийтийн тээвэр" хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд Сүхбаатар, Дархан-Уул аймгийн хооронд болон аймгийн төвд такси үйлчилгээ эрхэлдэг жолооч нарыг цуглуулан аймгийн "Архидалттай тэмцэх хөтөлбөр", "Тээврийн хэрэгслийг согтууруулах ундаа хэрэглэсэн үедээ жолоодохын хор уршиг" зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулж, "Хуулиа мөрдье-21" аянд нэгдүүлэв.

Ерөө сумын Засаг даргын Тамгын газраас сумынхаа хэмжээнд "Архинаас татгалзъя" 1 сарын аяныг зохион байгуулан ажиллаж, тус суманд үйл ажиллагаа явуулдаг согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгжүүдийн эзэд захирлууд, худалдагч нарт "Архидан согтуурахтай тэмцэх тухай хууль"-аар 1 удаагийн сургалтыг зохион байгуулж, "21 насанд хүрээгүй хүнд согтууруулах ундаа худалдахыг хориглоно" гэсэн зурагт хуудсуудыг согтууруулах ундаа худалдан борлуулдаг, түүгээр үйлчилдэг аж ахуйн нэгжүүдэд наан байршуулжээ.

Мөн Сүхбаатар суманд "Архидалтын эсрэг зохион байгуулах ажил", Ерөө суманд "Архинаас татгалзъя", Хүдэр суманд "Согтууруулах ундааны хяналтын тухай хуулийн төсөл", Мандал суманд "Байгууллага, аж ахуйн нэгжийн нийгмийн өмнө хүлээх үүрэг", Түшиг суманд "Согтууруулах ундааны хэрэглээг багасгах арга зам" сэдэвт хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулан ажилласан.

Хүдэр суманд "Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийг хэн сайн мэдэх вэ?" сэдэвт "АХА" тэмцээнийг сургуулийн сурагчдын дунд зохион байгууллаа.

Сүхбаатар сумын 1 дүгээр сургуулийн сурагчдын дунд "Хуулиа мөрдье-21" өдөрлөгийг зохион байгуулж, сурагчдын дунд "Архины хор уршиг" сэдвийн хүрээнд эссэ бичлэгийн болон гар зургийн уралдааныг зохион байгуулж, сурагчдын өөрсдийнх нь санаачлагаар "Хуулиа мөрдье-21" самбарыг хийж, "Амар тайван амьдралын төлөө-Архидалт, хүчирхийллийн эсрэг хамтдаа" сэдэвт зурагт хуудсыг бэлтгэн байгууллага, аж ахуйн нэгж, сургуулиудад тараан байршуулав.

Мөн Сайхан сумын ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд "Архигүй орчин бидний гэрэлт ирээдүй" өдөрлөгийг зохион байгуулж, 9-12 дугаар ангийн 350 сурагчид "Архины хор уршиг" сэдвээр сургалт, яриа таниулгыг хийлээ.

Аймгийн Мэргэжлийн хяналтын газар, Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газар, Сүхбаатар сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Боловсрол, соёл урлагийн газартай хамтран Сүхбаатар сумын 6 сургуулийн сурагчдын дунд "Архины хор уршиг" сэдэвт "Дэвжээ" тэмцээнийг зохион байгуулсан.

Согтуугаар зөрчил гаргаж, захиргааны журмаар баривчлагдсан хүмүүст "Архинд донтох өвчин", "Архидан согтуурахын хор уршиг", "Архидалттай тэмцэх хөтөлбөр", "Гэр бүлийн хүчирхийлэл ба архи", "Бид архигүй эрүүл орчинд", "Эерэг сэтгэлгээ" зэрэг сэдвүүдээр өдөр бүр сургалтыг зохион байгуулан ажилласан.

"Хуулиа мөрдье-21" арга хэмжээний хүрээнд зохион байгуулсан ажлаа сумдууд өөрсдийн цахим хуудсанд байршуулан иргэдэд хүргэлээ.

Цагдаагийн газраас өөрийн "Сэлэнгэ цагдаа" цахим хуудсанд мэдээллийг байршуулж, уг арга хэмжээнд иргэдийг нэгдүүлэх, сурталчлах ажлыг зохион байгуулсан. Орон нутгийн "Миний монгол энтертаймент" телевизээр мэдээллийг иргэдэд хүргэж, арга хэмжээг сурталчиллаа.

Сар шинийн баяр болохтой холбоотойгоор “Сар шинэ-2018” арга хэмжээг зохион байгуулж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Сэрэмжлүүлэг”, “Гэр хороолол-1”, “Гэр хороолол-4,8”, “Иргэддээ сэрэмжлүүлье” “Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлье”, зам тээврийн осол, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор “Сар шинэ-Аюулгүй тээвэр” сэдэвт хэсэгчилсэн арга хэмжээнүүдийг тус тус зохион байгуулсан.

Замын цагдаагийн албанаас Цагаан сарын баяр болохтой холбоотойгоор “Сар шинэ-Аюулгүй тээвэр” хэсэгчилсэн арга хэмжээний хүрээнд аймгийн Сүхбаатар, Шаамар, Алтанбулаг, Жавхлант сумдын нутаг дэвсгэрт төв замын дагуу хөдөлгөөнт эргүүлээр үүрэг гүйцэтгэж, Авто тээврийн газрын хяналтын улсын байцаагч, сумдын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн гишүүдтэй хамтран замын хөдөлгөөнд оролцож байгаа тээрийн хэрэгслийн хүн ба ачаа тээврийн хэрэгслийг шалгаж, хулгайн эд зүйл тээвэрлэж байгаа эсэхэд хяналт шалгалт хийв.

Зам тээврийн хэрэг, ослоос урьдчилан сэргийлэх чиглэлээр “Хурдаа хас!” санамж 316 ширхгийг тарааж, харанхуй буюу үзэгдэх орчин хангалтгүй үед замын хөдөлгөөнд оролцож байгаа жолооч нарыг Замын хөдөлгөөний дүрмээ биелүүлэн өөдөөс тээврийн хэрэгсэл ирж байгаа үед, тээврийн хэрэгслийн холын гэрлийг ойрын гэрэлд шилжүүлэн, хамгаалах бүс хэрэглэж, замын хөдөлгөөний дүрмээ биелүүлэн, гүйцэж түрүүлэх, саадыг тойрон гарахаас бусад тохиолдолд эсрэг урсгалд орохгүй байж замын хөдөлгөөнд соёлтой оролцож, замын нөхцөл байдалд хурдаа тохируулан хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж явах талаар зөвлөмжийг хүргэлээ.

Цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, Сүхбаатар сумын 3, 7 дугаар багийн хэсгийн байцаагч нар хамтран “Хуулийн хэрэгжилт” нэгдсэн арга хэмжээний хүрээнд аймгийн “Архидалттай тэмцэх хөтөлбөр”, Монгол Улсын Зөрчлийн тухай хуулийг иргэд олон нийтэд сурталчилж, Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 64 ажилтан, албан хаагчдад 2018 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулан ажилласан.

Цагдаагийн ерөнхий газрын тэргүүн дэд даргаас баталсан Хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг болон хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, Архидалттай тэмцэх, архины хор уршгийг сурталчлах чиглэлээр зохион байгуулах “Хуулийн хэрэгжилт” нэгдсэн арга хэмжээний төлөвлөгөөний дагуу салбар төлөвлөгөөг 2018 оны 02 дугаар сарын 28-ны өдөр боловсруулан гаргаж, харьяа Мандал, Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсүүд рүү хүргүүлэн төлөвлөгөөний дагуу тодорхой ажлуудыг зохион байгуулан ажиллаж байна.

Гэр бүлийн хүчирхийлэлттэй тэмцэх, хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр:Сэлэнгэ аймгийн хэмжээнд 2018 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн байдлаар гэр бүлийн хүчирхийллийн 12 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3 гэмт хэргээр буюу 25 хувиар өссөн, насанд хүрээгүй хүмүүсээс үйлдсэн 2 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх мөн үетэй харьцуулахад 6 гэмт хэргээр буюу 75 хувиар буурсан үзүүлэлтэй байна.

Тайлангийн хугацаанд Сүхбаатар сумын ерөнхий боловсролын 4 дүгээр бүрэн дунд сургуулийн 8-10 дугаар ангийн 109 сурагчид “Дэлгэцийн донтолт”, “Цахим гэмт хэрэг ба хүүхэд”, спортын гүнзгийрүүлсэн сургалттай ерөнхий боловсролын сургуулийн эцэг эхийн төлөөлөл болох 20 иргэн, 4 багшид “Зөрчлийн тухай хуулийн шинэчилсэн найруулга ба эцэг эх”, аймгийн Насан туршийн боловсролын Гэгээрэл төвтэй хамтран 18 иргэн, 6 сурагчид “Нэг тэрбумаараа тэмцье” хүчирхийллийн эсрэг хэлэлцүүлэг, сургалтыг тус тус зохион байгуулан ажиллаа.

Мандал сумын ерөнхий боловсролын 3 дугаар бүрэн дунд сургуулийн ахлах ангийн 298 сурагчдад “Мандал суманд хүүхдээс үйлдсэн гэмт хэргийн нөхцөл

байдлын судалгаа”, “Насанд хүрээгүй хүмүүст хүлээлгэх эрүүгийн хариуцлага” сэдэвт сургалт зохион байгуулж, мөн ерөнхий боловсролын 1 дүгээр бүрэн дунд сургуулийн 38 багш, ажилчдад, “Тэнгэр” худалдааны төвийн 35 ажилчин, худалдаачдад “Архигүй хамт олон” болох уриалга гардуулан өгч, “Зөрчлийн тухай”, “Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах тухай” хуулиудаар сургалт зохион байгуулж, мэдээлэл хийж ажиллаа.

“Спирт бал бурам” ХК-ний удирдлагын багийн хуралд оролцож, “Архигүй хамт олон” болох уриалга, “Хуулиа мөрдье-21” нэгдсэн арга хэмжээний постеруудыг гардуулан өгч, 2018 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтран зохион байгуулах ажил, арга хэмжээний талаар хэлэлцсэн байна.

Гэр бүлийн хүчирхийлэл, хүүхдийн эсрэг гэмт хэргээс урьчдилан сэргийлэх, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдсэн гэмт хэргийн шалтгаан, нөхцлийг арилгуулах зорилгоор Сэлэнгэ аймгийн Мандал сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсээс 2, Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсээс 3, мөрдөгч нараас 9, нийт 14 мэдэгдэл бичсэнээс 9 мэдэгдлийн хариу авч ажиллажээ.

Энэ улиралд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгч 12, гэмт хэрэг зөрчил үйлдэж болзошгүй насанд хүрээгүй хүн 8, гэмт хэрэгт уруу татагч 2, нийт 22 иргэнийг Цагдаагийн байгууллагын Мэдээллийн нэгдсэн сангийн “Судалгаа хяналтын сан”-д бүртгэж, мэдээллийг оруулсан байна.

Мөн энэ улиралд оршин суугаа газраасаа алга болсон насанд хүрээгүй 6 хүнийг эрэн сурвалжлах ажил зохион байгуулж 5 хүүхдийг 1-3, 1 хүүхдийг 7 хоногийн дотор байгаа газрыг олж тогтоон, эцэг эх, асран хамгаалагч нарт хүлээлгэн өгч, дахин гэрээсээ олон хоногоор явахгүй байх талаар бичгээр баталгаа гаргуулж, эцэг эх, асран хамгаалагч нарт хууль, эрх зүйн зөвлөгөө өгч ажиллаа.

Гэр бүлийн хүчирхийлэл хүүхдийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр орон нутгийн “Миний Монгол энтертаймент”, “Таны Сэлэнгэ”, “Мандал”, “Эрдэнэ” зэрэг телевизүүдэд нийт 2 удаа 20 минутын мэдээ, мэдээллийг 5 удаагийн давтамжтай нэвтрүүлж олон нийтэд сурталчилж ажилласан.

Цагдаагийн газрын “Сэлэнгэ Цагдаагийн газар”, “Мандал Цагдаагийн хэлтэс” facebook хуудас болон өсвөр насны хүүхдүүдийн хандалт ихтэй Сүхбаатар, Мандалын Залуус зэрэг пэйж хуудсуудад хариуцсан чиглэлээр зохион байгуулсан ажил, арга хэмжээ болон гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эцэг эхчүүдийг хүүхдэдээ тавих хараа хяналтаа дээшлүүлэх талаар нийт 5 мэдээлэл байршуулж, 128 хүн хандсан байна.

“Хуулиа мөрдье-21”, “Сэрэмжилье-Нэгдье” нэгдсэн арга хэмжээнүүд, “Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлье” сэдэвт цуврал, нэгдсэн сургалтын хүрээнд “Хүүхдийг гэмт хэргээс урьдчилан сэргийлье” зурагт хуудас 150, “Зогс” хүчирхийллийн эсрэг зурагт хуудас 150, “Хуулиа мөрдье 21” сэрэмжлүүлэг 200 ширхэг, “Хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлье” зурагт хуудас 200 ширхэг, нийт 700 ширхэг сэрэмжлүүлэг, зурагт хуудас бэлтгэж тараасан байна.

Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх чиглэлээр: Иргэдээс мал хулгайлах гэмт хэргийн шинжтэй 10 гомдол мэдээллийг хүлээн авч шалгаснаас 1 гомдол мэдээллийг хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзаж, 8 гомдол мэдээлэлд хэрэг бүртгэлтийн хэрэг нээн /1 хэрэгт өөр зүйлчлэлээр үүсгэсэн/ шалгаж, 1 гомдол мэдээлэл ажиллагаанд шалгагдаж байна.

Тухайн улиралд 15.550.000 òºãõºãèéí õî õèðî ëòî é 5 холбогдогчтой 7 ãýì ò õýðýã á¿ðòãýãäñýí í ü í èéò ãýì ò õýðãèéí 4.9 õóâèéã ýçýëæ áàéí à. Хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалтын шатанд 11.750.000 төгрөгийн хохирлыг нөхөн төлүүлсэн.

Орхон суманд тус сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлтэй хамтран 2018 оны 02 дугаар сарын 01-ний өдөр малчдын зөвлөгөөнийг зохион байгуулж, малын хулгайлах болон хулгайн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар хэлэлцэж, хэсгийн мөрдөгч, цагдаагийн ахлах дэслэгч

А.Агваандорж, малын хулгайн гэмт хэргийн нөхцөл байдлын талаар танилцуулж, урьдчилан сэргийлэх, талаар яриа таниулга хийлээ. Зөвлөгөөнд малчин болон мал бүхий нийт 112 иргэн хамрагдан оролцож, оролцогчдын шийдвэрээр “Нөхөрлөл” бүлгэм байгуулагдав.

Гурав.Сахилга хариуцлага, сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх болон авилгаас урьдчилан сэргийлэх ажлын талаар:

2018 оны 1 дүгээр улиралд Мандал сум дахь сум дундын Цагдаагийн хэлтсийн 7, Сайхан сум дахь сум дундын Цагдаагийн тасгийн 3, аймгийн төвийн 5, нийт 15 алба хаагч сахилгын зөрчил гаргасныг урьд оны мөн үетэй харьцуулбал 3-аар буюу 20,0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.Дээрх алба хаагчдын 8 буюу 53,3 хувь нь офицер, 7 буюу 46,7 хувийг ахлагч бүрэлдэхүүн эзэлж байна.

Нийт сахилгын зөрчлийг хэлбэрээр нь авч үзвэл:ЦАХ-ийн сахилгын дүрэм зөрчсөн 4 буюу 27 хувийг, архидан согтуурсан зөрчил 3 буюу 20 хувийг, ажлын хариуцлага алдсан болон ажил тасалсан, үүрэг даалгавар үл биелүүлсэн зөрчил тус бүр 2 буюу 13 хувийг, ЦАХ-ийн ёс зүйн дүрэм зөрчсөн болон төсвийн хөрөнгийг ашигласан зөрчил тус бүр 1 буюу 7 хувийг эзэлж байна.

Сахилга, ёс зүйн зөрчлийн шалтгаан нөхцлийг авч үзвэл 15 буюу 100 хувийг хувь хүний буруутай үйл ажиллагаанаас шалтгаалсан байна.

Сахилгын шийтгэлийг төрлөөр нь авч үзвэл албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах сахилгын шийтгэл оногдуулсан 7 буюу 46,5 хувь, сануулах сахилгын шийтгэл оногдуулсан 7 буюу 46,5 хувь, цагдаагийн цолыг бууруулах шийтгэл оногдуулсан 1 буюу 7 хувийг тус тус эзэлж байна.

Иргэд, байгууллагаас 2018 оны 1 дүгээр улиралд цагдаагийн 12 алба хаагчтай холбоотой 11 гомдол, мэдээлэл бүртгэгдсэн нь урьд оны мөн үетэй харьцуулбал 6-аар буюу 54,5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.Гомдол мэдээлэлд холбогдон шалгагдсан алба хаагчдын 5 буюу 45,4 хувь нь офицер, 7 буюу 54,6 хувь нь ахлагч алба хаагч байна.

Нийт гомдол, мэдээллийг зөрчлийн төрлөөр ангилбал хууль бус, хүний эрх, эрх чөлөөг зөрчсөн болон хэрэг материал дутуу шалгасан тус бүр 3, хээл хахууль, шан харамж авсан, архидан согтуурсан, Эрүүгийн болон бусад хууль тогтоомж зөрчсөн тус бүр 1, цагдаагийн алба хаагчийн харьцааны соёл, ёс зүй зөрчсөн-2 гомдол мэдээлэл байна.

Тухайн улиралд эрүүгийн хэрэгт холбогдсон алба хаагч байхгүй.Зөрчилд 2 алба хаагч холбогдож, арга хэмжээ тооцогдсон байна.

Тайлангийн хугацаанд аймгийн төвд болон Мандал сум дахь сум дундын цагдаагийн хэлтэст тус бүр 1, нийт 2 прокурорын шаардлага хүлээн авсан нь урьд оны мөн үетэй харьцуулахад 1-ээр буюу 33,3 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Шаардлагын дагуу 2 алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалинг үр дүнгээр 20 хувиар бууруулж, замын цагдаагийн зохицуулагч нарт зөрчил шалган шийдвэрлэх талаар зааварчилга хүргүүлсэн байна.

Цагдаагийн газрын 2018 оны 1 дүгээр улирлын “Сахилга хариуцлагын зөвлөгөөн”-ийг 03 дугаар сарын 23-ны өдөр зохион байгуулж, зөвлөгөөнөөр алба хаагчдын сахилга, ёс зүйн байдлыг 1 дүгээр улирлын байдлаар дүгнэсэн танилцуулгыг хэлэлцүүлж, сахилгын зөрчил гаргасан алба хаагчдын сонсголыг хэлэлцэж, хамт олны “Итгэл найдварын хуудас”-ыг гардуулав.

Алба хаагчдаас сахилгын зөвлөгөөнөөр дэвшүүлсэн саналуудыг дэмжиж, “Архигүй хамт олон болцгооё” уриалгыг гаргаж, хэрэгжилтийг ханган сахилгын зөрчлийн тоог бууруулж, биелэлт, үр дүнг 2018 оны эхний хагас жилд тооцохоор шийдвэрлэлээ.

Авлигаас урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажил, арга хэмжээний төлөвлөгөөний дагуу салбар төлөвлөгөө гарган харъяа хэлтэс, тасгуудад хүргүүлэн ажиллаж байна. 2018 оны 01 дүгээр сарын 22-ны өдөр Авилгатай тэмцэх газраас ХАСХОМ-ыг гаргах тайлбар гаргах, мэдүүлэх тухай, Офшор дансны тухай сургалтуудыг аймгийн төрийн алба хаагчдад зохион байгуулахад Цагдаагийн газрын мэдүүлэг гаргах алба хаагчдыг бүрэн хамруулсан.

Тус цагдаагийн газраас 125 офицер алба хаагчдын 2017 оны хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгийн баталгааны маягтуудыг эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагааны тайлангийн хамт гаргаж хүргүүлсэн.

Сургалт сурталчилгаа, соён гэгээрүүлэх ажлын талаар:Тус Öàãäàãàãèéí ãàçàð íü 2018 î íû õè÷ýýëèéí æèëèéí àëáàíû ñóðãàëòàар àëáà õàãàõäàä мэргэжлийн ур чадвар, дадлага эзэмшүүлэх, мэдвэл зохих хууль тогтоомж, болон бусад чиглэлээр хөгжүүлэх мэргэшүүлэх, î íî ëûí ì ýäëýã î ëãî õ, бие бялдрыг хөгжүүлэх çî ðèëãî ор àëáàíû ñóðãàëòûí òºëºâëºæºã ãàðãàí төлөвлөгөөний дагуу ñóðãàëòûã çî õèî íáàéãóóëàí àæèëëàж байна.

Ñóðãàëòûã Öàãäàãàãèéí ãàçðûí õýì æýýíä 2018 оны 01 дүгээр сарын 05-íы ºäðºñ ýõëýí 7 õî íî ãá¿ðèéí ëõàãàà, баасан ãàðàõ мэдвэл зохих хууль тогтоомжийн болон алба хаагчдыг хөгжүүлэх, мэргэшлүүлэх сургалтыг 09.30-10.30 öàãèéí õî î ðî íд лекц, семинар, дадлага хэлбэрээр зохион байгуулж байна.

Àëáàíû ñóðãàëò явуулах багийг Цагдаагийн газрын даргын 2018 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн А/02 дугаар тушаалаар Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч Т.Цэрэнбатаар ахлуулсан 8 хүний бүрэлдэхүүнтэй òî ì èлæ, Цагдаагийн газрын õýì æýýíä çî õèî íáàéãóóëàõ ñóðãàëòûã õàðèóöан ажиллаж байна.

Сургалтын багт тасаг бүрээс алба хаагч нар орсон бөгөөд эдгээр алба хаагчид нь тасгийнхаа сургалтыг хариуцан төлөвлөгөөг боловсруулж, нэгдсэн төлөвлөгөөнд тусгуулав.

Õè÷ýýëèéã ÿâóóëàõäàà Сургалтын багийн алба хаагчдад çàõ ñýäâèéã õóààðèëàí ºã÷ гарын авлага, ашиглах материалуудыг бэлтгүүлэн боловсруулуулж, àëáàíû ñóðãàëòûí бүртгэлийг õºòлөн, áèå á¿ðýëäýõ¿¿íèé õè÷ýýëèéí èðö, òóõàéí ºäºð çààñàí õè÷ýýëèéí ñýäâèéã áè÷èæ, õè÷ýýë çààñàí àëáà õàãàõàð ãàðûí ¿cýã çóðóóëæõýâø ñýí.

Мөн алба хаагчдын мэдээлэл боловсруулах, илтгэх чадварыг дээшлүүлэх зорилгоор зарим алба хаагчид тодорхой сэдвүүдийг хуваарилан өгч, сургалтын материал бэлтгүүлэн өөрсдөөр нь сургалтыг зохион байгуулж байна.

Ýíý õóãöàíä алба хаагчдын мэдвэл зохих хууль тогтоомжийн чиглэлээр 15 удаагийн 19 цагийн, алба хаагчдыг хөгжүүлэх ÷èãëýëýýð 10 óäàãèéí 14 öàãèéí, мэргэжлийн ур чадварын дээшлүүлэх болон дадлагажуулах чиглэлээр 15 удаагийн 17 цагийн нэгдсэн сургалтыг зохион байгуулж, áèå áÿëäðûã õºãæ¿¿ëýõ ÷èãëýëýýð 6 óäàãèéí 12 öàãèéí ñóðãàëòàíä цагдаагийн газрын áèå á¿ðýëäýõ¿¿í õàì ðàãäсан.

Зарим төрлийн сургалтыг төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран зохион байгуулж байна.Тухайлбал: Аймгийн шүүх, прокурорын газар, “Хувь хүний хөгжлийн институт”, “Монре даатгал” ХХК, Сүхбаатар сумын засаг даргын Тамгын газар зэрэг 5 байгууллагатай хамтран зохион байгуулаад байна.

Цагдаагийн ерөнхий газрын даргын 2018 оны А/46 дугаар тушаалаар батлагдсан “Цагдаа, дотоодын цэргийн алба хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх 2018 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу Цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сургалтын нэгдсэн төв, Цагдаагийн ерөнхий газрын автобаазад 2018 оны 03 дугаар сарын 14-16-ны өдрүүдэд нийт 4 удаагийн сургалтанд 5 алба хаагч хамрагдлаа.

Мөн 2017 онд сахилга ёс зүйн зөрчил гаргасан 14 алба хаагчийг сургалтанд хамруулах талаар ЦЕГ-ын дэд даргын 2018 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн “Алба хаагчдыг ёс зүйн төлбөртэй сургалтанд хамруулах тухай” Б/03, Б/04 дугаартай тушаалуудын дагуу цагдаа, дотоодын цэргийн байгууллагын сургалтын нэгдсэн төвд 03 дугаар сарын 19-20, 21-23-ны өдрүүдэд сургалтанд хамруулав.

Аймгийн Биеийн тамир, спортын газартай гэрээ хийж, 2018 оны хичээл сургалтын төлөвлөгөөний дагуу долоо хоногийн “Мягмар” гараг бүр Спортын ордонд 18.00-20.00 цагийн хооронд бие áÿëäðû ã õº ãæ¿¿ëýõ ÷èãëýëýýð 6 удаагийн 12 цагийн сургалтыг áèåýð õèéæ ã¿éöýòãýõ äàñãàëóóä, ñàãñан болон гар бөмбөг, теннис òî ãëî õ õýëáýðýýð çî õèî í áàéãóóëж байна.

Соён гэгээрүүлэх ажлын чиглэлээр:Цагдаагийн газрын хэмжээнд ЦБҮАЖурам “Соён гэгээрүүлэх ажил” /код 940/-ын хэрэгжилтийг хангах, алба хаагчдын ажлын стрессийг бууруулах, чөлөөт цагийн зөв боловсон өнгөрөөх, соён гэгээрүүлэх чиглэлээр 2018 онд хэрэгжүүлэх 22 заалт бүхий ажлын төлөвлөгөөг боловсруулан, соён гэгээрүүлэх ажлыг сар бүр хэлтэс, тасгууд хариуцан зохион байгуулахаар хуваарь гарган хуваарийн ажил, арга хэмжээ зохион байгуулж байна.

Тайлангийн хугацаанд аймгийн хэмжээнд зохион байгуулагдсан “Цасны баяр”-ын арга хэмжээнд оролцож, зохион байгуулагдсан 4 тэмцээнд алба хаагчдыг идэвхитэй оролцуулах ажлыг зохион байгуулж, “Цасны сум” эмэгтэй төрөл, “Олс таталт”, “Чаргатай буухиа” тэмцээнүүдэд тэргүүн байр эзэлж, “Спортлог хамт олон”-оор шалгарлаа. Мөн уг арга хэмжээний үед алба хаагчдынхаа дунд “Дартс”, “Шагайгаар морь уралдах”, “Сээр хуга цохих”, “Цасны хөл бөмбөг” зэрэг тэмцээнүүдийг зохион байгуулж, түрүүлсэн баг, алба хаагчдыг шагнаж урамшуулав.

Алба хаагчдын багаар ажиллах чадварыг нэмэгдүүлэх, стрессийг бууруулах зорилгоор “Үүнийг надад хэн ч хэлээгүй ” сэтгэл зүйн сургалтыг “Манжингийн үлгэр” сэдвээр жүжигчилсэн тоглолт хэлбэрээр хөгжөөнт байдлаар зохион байгуулж, үлгэрийн баатруудын дүрд Цагдаагийн газрын ахлах мэргэжилтэн, байцаагч нар тоглож, алба хаагчдыг хөгжөөлөө.

Монголын уламжлалт “Сар шинэ”-ийн баярыг тохиолдуулан алба хаагчдын дунд үндэсний дээл хувцсаа сурталчлах зорилгоор “Дээлтэй монгол” арга хэмжээг зохион байгуулж, уг арга хэмжээний хүрээнд монгол дээл хувцсаа хамгийн сайхан өмссөн алба хаагчдыг шалгаруулж, “Хэн нь 32 цагаан лонхыг сайн тоолох вэ?”, “Монгол ардын оньсого хэн сайн таах вэ?”, “Хэн нь 10 секундэд олон бууз идэх вэ?” зэрэг сэдэвт хөгжөөнт тэмцээнүүдийг зохион байгуулав.

Дөрөв.Санхүү бүртгэл, хангамж үйлчилгээний талаар:

Тайлангийн хугацаанд “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Төсвийн тухай хууль” болон бусад хууль эрхзүйн баримт бичгийг үндэслэл болгон төсвийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй зарцуулан, бүртгэлээр тавих хяналтыг сайжруулах, цагдаагийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах, цагдаа, дотоодын цэргийн байгууллагаас 2018 онд дэвшүүлсэн зорилтыг хэрэгжүүлэх, ажилчдын цалин хөлс, нийгмийн асуудалд анхаарал тавин, төсвийг зориулалтын дагуу зарцуулж, өр авлагагүй байх зорилт тавин ажиллалаа.

Орлого санхүүжилтын талаар:Tº ñâèéí ñàí õ¿¿æèëòýýð 156382,4 ì ÿí ãàí òº ãðº ã òº ñº âëº ãäñøí º º ñ ã¿éöýòãýëýýð ñàí õ¿¿æèëò 100 õóâüòàé байна.

¯í äñýí áî ëî í ¿í äñýí áóñ ¿éë àæèëëàãààí û î ðëî ãû í òº ëº âëº ãº º 1250,0 мянган төгрөг áàòëàãäàæ, ã¿éöýòãýëýýð 1345,7 ì ÿí ãàí òº ãðº ã байна.Үүнээс:Эрүүлжүүлэх, саатуулах байрны орлого 1027,2 мянган òº ãðº ã, òýýâðèéí õýðýãñýë хадгалах байрны орлого 318,5 мянган òº ãðº ã тус тус оруулсан байна.

Зарцуулалтын талаар: Цалин хөлс, болон нэмэгдэл урамшил, ажиллагсадтай холбогдон гарсан зардал хэвийн гүйцэтгэлтэй.

Байр ашиглалтын зардлын хувьд төсвийн дагуу зарцуулж, өглөг, авлагын тооцоогүй.Байгууллагын хэвийн ажиллагааны болон нормитив зардалд гүйцэтгэл гараагүй байна.Шатахууны гүйлгээ 7,0 сая төгрөг хийгдсэн.

Санхүүгийн жилийн эцсийн гүйцэтгэлийн тайланг нэгтгэж, ЦЕГ-ын дотоод хянан зааварлагчаар хянуулж, эд хөрөнгийн ашиглалт, бүртгэл судалгааг зааварчилгааны маягт шийдвэрийн дагуу хийж, нэгтгэлд оруулсан.Санхүүгийн тооцоолох компанитай гэрээний сунгалт хийсэн.

2018 оны цалингийн санхүүгийн няравын програмын архив хийлгэж, шинэ оны баазад хөрвүүлж программын шинэчлэлт хийлгэсэн.

Аудитын байгууллагад санхүүгийн анхан шатны баримт холбогдох хавсралтын дагуу хийгдэх судалгааг гаргаж, тайланг урьд оны зөвлөмжийн биелэлтийн хамт хүргүүллээ.

ЦЕГ-ын даргын А/124 тоот тушаалаар алба хаагчдын төрийн тусгай алба хаасаны нэмэгдэл, 2017 оны цалингийн дэлгэрэнгүй судалгааг гаргаж файлаар хүргүүлэв.

Шилэн дансны системд шилэн дансны мэдээллийг бүтэн жилээр нь нэг бүрчлэн хуулийн хугацаанд нийтэлж, тайланг хүргүүлэв.2018 оны 1 дүгээр улиралд сар бүр мэдээлэх мэдээллийг хуулийн дагуу оруулж, 5 сая төгрөгөөс дээш гүйлгээ бүрийг журмын дагуу нийтлэж ажиллалаа.

Үнэт цаасны тооцоог сар бүр ЦЕГ-тай тулгалт хийж, өглөг авлагын тооцоогүй байна.

Тав.Алба хаагч, ажилтны ажиллах нөхцөл, нийгмийн асуудлыг хангах, эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр:

“Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам” /код-947/-ын “Ахмадын байгууллага, ахмад настны талаар авах арга хэмжээ” журмын хэрэгжилтийг хангах, ахмад ажилтнуудад хүндэтгэл үзүүлэх, ахмад ажилтнуудаас хамт олон, хойч үеийн залуу алба хаагчдад мэдлэг, туршлагаасаа хуваалцах, цаашид хэрхэн ажиллах талаар зөвлөн туслах боломжийг олгох, алба хаагчдын албандаа хандах хандлагад эерэг түлхэц үзүүлэх, албаараа бахархах сэдлийг төлөвшүүлэх, хамт олны нэгдэл нягтралыг бататгах зорилгоор “Соён гэгээрүүлэх ажил”-ын хүрээнд ахмадын зөвлөлтэй хамтран “Хишиг өдөр” арга хэмжээг 2017 оны 02 дугаар сарын 02-ны өдөр зохион байгуулж, тус арга хэмжээнд нийт 62 ахмад ажилтан хамрагдав.

Уг арга хэмжээний үед Цагдаагийн газрын дарга, цагдаагийн дэд хурандаа, А.Энхбат сар шинийн мэндчилгээ дэвшүүлж, Цагдаагийн газрын даргаар ажиллаж байсан зарим удирдлагууд цахим хэлбэрээр мэндчилгээ дэвшүүлсэнийг алба хаагч, ахмад ажилтануудад хүргэлээ.

Цэргийн алба хаасны тэтгэвэрт гарсан Эрүүлжүүлэх, саатуулах байрны дарга эмч, цагдаагийн бэлтгэл хошууч Б.Наранцацрал, Цагдаа жолооч, цагдаагийн бэлтгэл ахлах ахлагч Г.Төгсбаяр нарт хамт олноос, цагдаагийн хошууч Б.Наранцацралд “Эмэгтэйчүүдийн зөвлөл”-өөс хүндэтгэл үзүүлэн гарын бэлэг, ЦЕГ-ын даргын тушаалаар ”Монгол цагдаа” медиалиар шагнасныг тус тус гардуулсан.

Ахмад ажилтанууд өөрсдийн хийж гүйцэтгэж байсан ажлын туршлагыг хойч залуу үедээ зааж зааварлах, ажил мэргэжлийн талаас зөвлөгөө өгөх ажлыг зохион байгуулж, ахмад ажилтнуудыг Сэлэнгэ аймгийн Алтанбулаг сумын Ардын хувьсгалын түүхэн музей үзүүлж, тэдэнд хамтдаа халуун дотно яриа өрнүүлэх боломжийг бүрдүүлэн, “Amercan irish” зоогийн газарт хүндэтгэлийн зоог барьж, ардын дуурь бүжгийн Сэлэнгийн долгио чуулгын уран бүтээлчид болон Цагдаагийн газрын алба хаагчдаас урлагийн тоглолт үзүүлсэн. Тус арга хэмжээний хаалтын үйл ажиллагааны үеэр нийт ахмад ажилтнуудад гарын бэлэг гардуулав.

Алба хаагчдын нийгмийн баталгааг хангах чиглэлээр эмэгтэй алба хаагчид болон эрэгтэй алба хаагчдын гэр бүлийн хүмүүсийн амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, тэдний ажлаас үүссэн стрессийг бууруулах зорилгоор “Эзэгтэй нарын аялал” арга хэмжээг 2018 оны 02 дугаар сарын 03-ны өдөр зохион байгуулж, эмэгтэй алба хаагчид болон алба хаагчдын гэр бүлийн төлөөлөл болох нийт 32 хүн ОХУ-ын Буриад улсын Хиагт хот руу 1 өдрийн аялал хийлээ.

Аймгийн Нэгдсэн эмнэлэгтэй хамтран 2018 оны 1 дүгээр улиралд нийт алба хаагчдыг эмнэлгийн оношилгоо үйлчилгээнд хамруулахаар шийдвэрлэж, бэлтгэл ажлыг хангаж байна.

Зургаа: Дотоод хяналтын хүрээнд

Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны журам “Цагдаагийн байгууллагын хяналт шинжилгээ, үнэлгээг хийх” /код-110/-ыг хэрэгжүүлэх зорилгоор Цагдаагийн газрын даргын баталсан удирдамж төлөвлөгөөний дагуу улирал бүр харъяа хэлтэс, тасаг, хэсгийн үйл ажиллагааг шалгаж, дүнг Цагдаагийн газрын даргын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.

2018 оны 1 дүгээр улиралд нийт 15 алба хаагч сахилгын зөрчил гаргаснаас 9-г дотоодын хяналт, шалгалтаар илрүүлж, хариуцлага тооцсон нь сахилгын зөрчлийн 60 хувийг эзэлж байна.

Тухайн улиралд иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээлэл болон дотоодын хяналт шалгалтаар илрүүлсэн зөрчлүүдэд 22 албаны шалгалтыг явуулсан нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 12-оор буюу 54,5 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

Иргэд, байгууллагаас ирүүлсэн гомдол мэдээлэл бүрт албаны шалгалт явуулж, дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, буруутай нь тогтоогдсон 1 алба хаагчийг албанаас халах саналтай, 1 алба хаагчийн цагдаагийн цолыг бууруулж, 1 алба хаагчийн гомдлыг Авлигатай тэмцэх газарт харъяаллаар шилжүүлж, 2 алба хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалинг 3 сар хүртэл 20 хүртэл хувиар бууруулж, 6 алба хаагчид сахилгын арга хэмжээ тооцох үндэслэлгүй байх тул алба хаагчид зөвлөлийн хуралдаанаас анхааруулан үүрэг чиглэл өгч, гомдол гаргагч нарт хариуг өгч шийдвэрлэв.

Алба хаагчдын сахилга, хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор албаны шалгалт явуулсан материалуудад алба хаагчдаар дүн шинжилгээ хийлгэж, зөрчил дутагдал гарах болсон шалтгаан, цаашид энэ төрлийн зөрчил дутагдлаас хэрхэн урьдчилан сэргийлэх, анхаарах асуудлыг талаар дүгнэлт гаргуулан нийт алба хаагч нарт танилцуулж, сахилгын зөрчил дутагдлаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж байна.

Цагдаагийн ерөнхий газраас батлагдсан удирдамжийн хүрээнд 2018 оны 03 дугаар сарын 04-ний өдрөөс мөн оны 03 дугаар сарын 14-ний өдрүүдэд тус цагдаагийн газрын үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалтыг явуулж, “Цагдаагийн байгууллагын дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах журам”-д заасан аргачлалаар үнэлэн 76,4 оноо буюу “Хангалттай” үнэлгээтэй дүгнэгдсэн.

Долоо: Дүгнэлт

1.Аймгийн хэмжээнд өнгөрсөн 2017 онд 726 холбогдогчтой, 1698.5 сая төгрөгийн хохиролтой, 729 гэмт хэрэг бүртгэгдэж, нийт гэмт хэрэг 60 хэргээр буюу 9.0 хувиар урьд оны мөн үеэс өссөн байгаад дүгнэлт хийж 2018 онд гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр дүнг сайжруулах, орон нутгийн онцлогт тохирсон ажил, арга хэмжээг зохион байгуулах

2.Улирал бүр гэмт хэрэг, зөрчлийн тоо өссөн сумдын хэсгийн төлөөлөгч, цагдаа нарын сонсголыг авч хэлэлцэх.

3.2018 онд харъяа нэгжийн үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийх төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах, дүн шинжилгээ хийж, үр дүнг тооцох

4.Цагдаагийн ерөнхий газрын А/754, 2018 оны А/45 дугаартай “Эрх олгох тухай” тушаал, Нийтийн хэв журам хамгаалах газрын даргын 2017.08.30-ны өдрийн нэгжүүдэд хүргүүлсэн үүрэг, ажлын чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах

5.”Цагдаагийн байгууллагын сургалтын 2016-2019 онд хэрэгжүүлэх хөтөлбөр”-ийн дагуу албаны сургалтыг зохион байгуулж, чанар, үр дүнг дээшлүүлэх ажлуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ ЦАГДААГИЙН ГАЗАР